

Улсын төсвөөс 2013 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлан



Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж бүрэн хэрэгжээгүй байна

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар	2
Гүйцэтгэлийн аудитын газрын дарга-тэргүүлэх аудитор С.Төмөрхүү	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
Хөрөнгө оруулалтын албаны менежер Г.Гүнжидмаа	Бүлэг 1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг хуулийн дагуу төлөвлөөгүй байна	5
Ахлах аудитор С.Сэрчхорол	<ul style="list-style-type: none"> • Ерөнхий мэдээлэл 	5
Б.Саруул	<ul style="list-style-type: none"> • 2013 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оноос буурчээ 	5
Ш.Энхтайван	<ul style="list-style-type: none"> • Төсвийн тухай хуульд ТЭЗҮ, зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээ, барилга байгууламж батлагдсаар байна 	9
Ц.Цэрэндорж		
Д.Гандолгор		
Аудитор С.Одонцэцэг	Бүлэг 2 Худалдан авах ажиллагаанд гарч байсан өмнөх онуудын зөрчил арилаагүй байна	11
М.Доржмаа	<ul style="list-style-type: none"> • Ерөнхий мэдээлэл 	11
Э.Уянга	<ul style="list-style-type: none"> • Нийт тендер шалгаруулалтын 66.7 хувийг нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулжээ 	11
Ц.Цолмон	<ul style="list-style-type: none"> • Худалдан авах ажиллагааны аргыг буруу сонгосон зөрчил гарч байна 	13
Шинжээч Г.Батсүх	<ul style="list-style-type: none"> • Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад 200-398 хоног зарцуулж байна 	16
Б.Анхбаатар		
УАГ-ын гүйцэтгэлийн аудитын газар болон аймаг, нийслэлийн аудитын газрын аудитор, шинжээч нар	Бүлэг 3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн хэрэгжилт хангалтгүй байна	18
2014 оны 6 дугаар сар	<ul style="list-style-type: none"> • Ерөнхий мэдээлэл 	18
Уг тайланг УАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	<ul style="list-style-type: none"> • Эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна 	19
www.mnao.pmis.gov.mn	<ul style="list-style-type: none"> • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж он дамжин үргэлжилж байна 	21
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263755, 262451, 261675 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу	<ul style="list-style-type: none"> • Гүйцэтгэгчид хэд хэдэн ажил давхар гүйцэтгэж байгаа нь хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна 	22
	<ul style="list-style-type: none"> • Хяналтын үр нөлөөтэй тогтолцоо дутагдаж байна 	23
	<ul style="list-style-type: none"> • 2013 онд батлагдсан хөрөнгийн 70.1 хувийг санхүүжүүлжээ 	25
	Дүгнэлт	29
	Холбогдох байгууллагын санал	30
	УАГ-аас өгөх тайлбар	32
ХАЯГ: Үндэсний аудитын газар Засгийн газрын IV байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс	Зөвлөмж	33

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
АТГ	Авлигатай тэмцэх газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХС	Батлан хамгаалахын сайд
БХЯ	Батлан хамгаалахын яам
БОНХС	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд
БУА	Барилга угсралтын ажил
БЗА	Барилга захиалагчийн алба
БЗД	Баянзүрх дүүрэг
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ГХС	Гадаад харилцааны сайд
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕТГ	Ерөнхийлөгчийн Тамгын газар
ЕС	Ерөнхий сайд
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗТС	Зам тээврийн сайд
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МТШХХГ	Мэдээлэл, технологи, шуудан, харилцаа холбооны газар
ХЗС	Хууль зүйн сайд
СЯ	Сангийн яам
ССАЖС	Соёл, спорт аялал жуулчлалын сайд
СХД	Сонгино хайрхан дүүрэг
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТТХГ	Төрийн тусгай хамгаалалтын газар
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТНЖБТХ	Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль
ТӨААТҮГ	Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газар
ТЗҮААЭГ	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТӨХ	Төрийн өмчийн хороо
УБТЗ ХНН	Улаанбаатар төмөр зам, хувь нийлүүлсэн нийгэмлэг
УУС	Уул уурхайн сайд
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
УДШ	Улсын дээд шүүх
ҮХААС	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
УАГ	Үндэсний аудитын газар

ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮХЦ	Үндсэн хуулийн цэц
ҮТП	Үйлдвэрлэл технологийн парк
СБД	Сүхбаатар дүүрэг
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
СХЗГ	Стандарт, хэмжил зүйн газар
ЦАУЗБУК	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ХС	Хөдөлмөрийн сайд
ХАХНХС	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ЭЗХС	Эдийн засгийн хөгжлийн сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭХС	Эрчим хүчний сайд
ЧД	Чингэлтэй дүүрэг
ШС	Шадар сайд
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

1. Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газр аас 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон УАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2. Аудитын зорилт

Улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд,

- Хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй эсэх;
- Худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүнтэй эсэх.

3. Хамарсан хүрээ

Аудитад төсвийн ерөнхийлөн захирагчид, тэдний эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудыг хамруулав.

Харин БХЯ, ТЕГ, АТГ, ТТХГ, МТШХХГ, УАБАЗ -ийн зарим худалдан авах ажиллагаа ТНЖБТХ, ТБОНӨХБАУХАТХ-ийн дагуу “нууцын зэрэглэл”-д хамаарагдсан, мөн ТЕЗ-ийн багцын зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж хуулийн байгууллагуудад шалгагдаж байгаа учраас аудитад хамрагдаагүй болно.

УИХ-ын 2013 оны 63 дугаар тогтоолын дагуу “2014 оны төсвийн тухай хуулинд “0,0” дүнтэй тусгагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитаар шалгасан 243 барилга байгууламжийг хамруулаагүй болно.

4. Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлагын дагуу аудитын тайлангийн дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох үйлс, холбогдох мэдээ судалгаанд тулгуурлан дараах ажлыг гүйцэтгэв. Үүнд,

- Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр батлагдсан хөрөнгө оруулалтын судалгааг гаргуулан авч нэгтгэн дүгнэв.
- Улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд хийсэн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийлээ.
- Сангийн яамнаас хөрөнгө оруулалтын талаар шаардлагатай судалгаа, материалыг гаргуулан, ярилцлага хийж, тодруулга авлаа.
- Худалдан авалтыг ТБОНӨХБАУХАТХ-ийн дагуу хийгдсэн эсэхийг шалгав.
- Орон нутагт эрх нь шилжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтад аймаг, нийслэлийн аудитор, шинжээчид аудит хийлээ.

Бүлэг 1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг хуулийн дагуу төлөвлөөгүй байна

Ерөнхий мэдээлэл

1.1 Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг төсөвт тусгуулах санал нь Үндэсний хөгжлийн цогц бодлогын 4.4, 4.5 дах заалт, Засгийн газрынүйл ажиллагаа ны өтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтууд, төсвийн хүрээний мэдэгдэл, салбарын бодлого, төсвийн чадавхид үндэслэсэн байх шаардлагатай билээ.

1.2 2013 оны өсвийн хүрээний мэдэгдэлд улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээг 2,491.6 сая төгрөг байхаар тогтоосон бөгөөд Засгийн газрын 2012 оны "Зарлагын хязгаарыг батлах тухай" 214 үгээр тогтоолоор хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 1,600.1 тэрбум төгрөгт багтааж боловсруулахыг ТЕЗ нарт даалгажээ.

1.3 Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 3,189.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 1225 арга хэмжээнд 1,550.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор баталжээ.


1.4 2013 оны төсвийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 527.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 425.9 тэрбум төгрөгийн санхүүжүүлэх дүнтэй 253 төсөл, арга хэмжээ хасагдаж, 2,662.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 972 арга хэмжээг 1,124.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр хуульчилжээ. (Хавсралт № 1)

1.5 2013 оны улсын өсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө ДНБ-ий 6.4 хувийг эзэлж байна.

2013 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оноос буурчээ

1.6 Улсын төсвийн хөрөнгө оруулалт 2000 онд 29.6 тэрбум, 2005 онд 59.3 тэрбум төгрөг байсан бол 2009 оноос 2012 он хүртэл тасралтгүй өсч, харин 2013 онд өмнөх оноос 6.9 хувиар буурсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сүүлийн 6 жилийн байдлаар графикаар харуулбал, (тэрбум төгрөгөөр)



1.7 2009-2013 оны нэгдсэн өс вийн зарлагын днд эзлэх улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулав.

(тэрбум төгрөгөөр)

д/д	Үзүүлэлт	Гүйцэтгэл (оноор)				
		2009	2010	2011	2012	2013
1	Нэгдсэн төсвийн орлого	1 994.0	3 122.5	4 227.2	4 881.2	5 940.1
2	Нэгдсэн төсвийн зарлага	2 336.6	3 080.7	4 997.0	6 017.8	6 164.7
3	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	374.6	473.2	901.4	1 119.5	787.8
4	Төсвийн нийт зардалд эзлэх хөрөнгө оруулалтын хувь	16.0	15.4	18.0	18.6	12.8


*Эх сурвалж, 2009, 2010, 2011, 2012, 2013 оны нэгдсэн өсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан

1.8 2009-2013 оны нэгдсэн төсвийн зард алд улсын төсвийн хөрөнгө оруулалтын эзлэх хувийн жин дунджаар 16.2 хувь байгаа бол, 2013 онд 3.4 пунктээр буурч, 12.8 хувьтай байна.

1.9 2013 оны улсын өсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлахдаа 3 арим ТЭЗ-ын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлагдсан төсвийн хязгаараас хэтрүүлэн баталсан байна. Тухайлбал,

- ✚ ЕС-ын багц 27,093.0 сая;
- ✚ ХЗС-ын багц 30,476.2 сая;
- ✚ БХС-ын багц 6,238.9 сая төгрөгөөр тус тус илүү баталжээ.

1.10 Хөрөнгө оруулалтад батлагдсан төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг бүтцээр нь авч үзвэл, барилга байгууламж барихад 894.5 тэрбум, тоног өхөөрөмж, тавилга, эд хогшил худалдан авахад 103.7 тэрбум, их засварын зардалд 46.3 тэрбум, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулахад 79.8 тэрбум төгрөг зарцуулахаар баталжээ. Үүнийг графикаар харуулбал,



1.11 Тайлант онд барилга байгууламжид зарцуулахаар батлагдсан хөрөнгө нь өмнөх оноос 136.4 тэрбум төгрөг буюу 13.2 хувиар, тоног төхөөрөмж худалдан авах зардал 18.1 тэрбум төгрөгөөр буюу 14.8 хувиар, их засварын зардал 9.2 тэрбум төгрөгөөр буюу 16.5 хувиар тус тус буурсан бол ТЭЗҮ, зураг төсөл боловсруулахад 79.8 тэрбум төгрөг нэмж батлагдсан байна.

1.12 2013 онд улсын төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтыг салбарын хэмжээнд 2012 онтой харьцуулж үзвэл,

(тэрбум төгрөгөөр)

№	Салбар	2012 он		2013 он		Зөрүү
		Дүн	Хувь	Дүн	Хувь	
1	Дэд бүтэц	601.2	49.8	554.3	49.3	-46.9
2	Нийгэм	336.1	27.8	223.0	19.8	-113.1
3	Үйлдвэр, хөдөө аж ахуй	49.9	4.1	54.8	4.9	+4.9
4	Байгаль орчин	21.3	1.8	4.5	0.4	-16.8

5	Бусад	199.9	16.5	287.7	25.6	+87.8
Нийт дүн		1208.4	100.0	1124.3	100.0	-176.8/+92.7

1.13 Дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалт өмнөх оноос 46.9 тэрбум төгрөгөөр буурсан нь зам тээврийн салбарын хөрөнгө оруулалтыг “Чингис” бонд болон Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

1.14 Харин нийгмийн салбарын хөрөнгө оруулалтаас боловсрол, шинжлэх ухааны салбар 17.4 тэрбум, эрүүл мэндийн салбар 41.7 тэрбум, хүн, амын хөгжил, нийгмийн хамгааллын салбар 41.5 тэрбум, соёл, спорт, аялал жуулчлалын салбар 6.6 тэрбум, хөдөлмөрийн салбар 5.9 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

1.15 Бусад салбарын хувьд хөрөнгө оруулалт өмнөх оноос 43.9 хувиар өс сөн байна. Үүнд,

- + ЕС-ын багцын хөрөнгө оруулалт 31.4 тэрбум төгрөг байсан бол 2013 онд 91.4 тэрбум төгрөг болж 60.0 тэрбум;
- + ЭЗХС-ын багц 12.6 тэрбум төгрөг байсан бол 2013 онд 52.1 тэрбум төгрөг болж 39.5 тэрбум;
- + ШС-ын багц 14.7 тэрбум төгрөг байсан бол 2013 онд 22.9 тэрбум төгрөг болж 8.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

1.16 Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд Ерөнхий сайдын багцад шинэчлэлийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг 50.0 тэрбум төгрөгөөр баталжээ.

1.17 УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2013 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 02 дугаар тогтоолоор 2013 онд хэрэгжүүлэх шинэчлэлийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр төрөл, тоо хэмжээ, төсөвт өртгийн хэмжээг баталж, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг чиглэл болгосон байна. Үүнд,

Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээ.

(сая төгрөгөөр)

№	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	Хийгдэх ажлууд	Төсөвт өртөг
1	Замын цагдаагийн торгуулийг бэлнээр төлдөггүй, тасалбарын систем нэвтрүүлэх	350 ширхэг гар компьютер, хэвлэгч машин худалдан авах, програм хангамжжээг бий болгох	1,800.7
2	Иргэдэд шаардлагатай лавлагаа, мэдээлэл өгөх автомат машинуудыг байрлуулах	120 автомат киоск машинуудыг УБ хот болон 21 аймгийн төвд байрлуулах	2,000.0
3	Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй шуурхай болгох	Шуудангийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй шуурхай болгох	1,929.0
4	Аймгийн өмгүдэд битүү зах, худалдааны төв барихад хөрөнгө оруулах	Ховд, Баян-Өлгий, Увс аймгуудад худалдааны битүү төв барих	9,768.0
5	Аймгуудын нэгдсэн оношлогооны төв бий болгох	11 аймагт оношлогооны төв байгуулах, УБ хотод эх, ураг, нярайн тусламж үйлчилгээний төв байгуулах	25,977.1
6	Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд хөрөнгө оруулалт хийх	Гадна спортын цогцолбор болон дугуй, цана, гүйлтийн хосолсон зам, дугуйн зогсоол байгуулах	5,335.4
7	Залуучуудын үйлчилгээний цогцолбор босгох	Хүүхэд залуучуудын төвийг иргэд чөлөөт цагаа гэр бүлийн хамт өнгөрөөх үйлчилгээний төв болгоход хөрөнгө оруулалт хийх	3,189.0
Нийт дүн			49,999.2

1.18 Улсын өсвийн хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөгүйгээс төсөвт тусгуулахаар аймаг, орон нутаг, ТЭЗ-аас эдийн засгийн болон нийгмийн ач холбогдол, хуулийн шаардлагад нийцээгүй төсөл, арга хэмжээний санал ирүүлж байгаагаас хуулинд бүрэн тусгах боломжгүй байна. Тухайлбал,

- ✦ Сэлэнгэ аймгаас 14,072.1 сая төгрөгийн 44 төсөл, арга хэмжээ г хэрэгжүүлэх санал ирүүлсэн боловч 4 арга хэмжээ батлагдсан;
- ✦ НЗДТГ-аас 7 салбарт нийт 345,966.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 273 төсөл, арга хэмжээг 2013 онд хэрэгжүүлэхээр санал хүргүүлснээс 99 ,700.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 135 төсөл, арга хэмжээ тусгагдсан;
- ✦ ШС-ын багцаас 6 агентлагт 117,675.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 157 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр санал хүргүүлсэн ч 46,545.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 47 төсөл, арга хэмжээнд 2013 онд 22,899.7 сая төгрөгийн санхүүжилт хийхээр батлагдсан байна.

1.19 ЭЗХС-ын эрхлэх асуудлынүрээнд улсын хэмжээнд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ТЭЗҮ, зураг, төсөв боловсруулах төсөв батлагддаг бөгөөд ТЭЗ-аас 2013 онд 683 арга хэмжээний 111.3 тэрбум төгрөгийг төсөвт тусгуулах санал ирүүлжээ.

1.20 Тус яам нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийгмийн хэрэгцээ, шаардлага, ач холбогдол, үр өгөөж, тэргүүлэх чиглэлээр эрэмбэлсэн нэгдсэн төлөвлөгөө хийгээгүйгээс 2013 онд ямар барилга байгууламжийн ТЭЗҮ, зураг төсвийг боловсруулах нь тодорхойгүй байна.

1.21 УИХ-аар төсвийн хууль батлагдах үед эрчим хүчний салбарын санал дээр 2012 оноос шилжсэн цахилгаан дамжуулах шугам, дэд станцын 10, 2013 онд 2, дулааны цахилгаан станц, дулааны шугам 1 нийт 29,148.8 сая төгрөгийг нэмж баталжээ.

1.22 Мөн Ховд аймгийн Жаргалант суманд 2013 онд цахилгаан дамжуулах агаарын дэд шугам, дэд станц барихад 1,750.0 сая төгрөгийг санал авалгүйгээр шууд тусгажээ.

1.23 ЗГХЭГ-т батлагдсан төлөвлөгөөг төсвийн төсөлд өгсөн саналтай харьцуулахад 11 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр санал өгсөн боловч УИХ-ын гишүүдийн санал болон тодотголоор 16 төсөл, арга хэмжээг нэмж баталсан байна.

1.24 Эдгээр нь ТЭЗҮ, баталгаажуулсан зураг, төсөв, үр ашгийн тооцоо судалгаагүй, өмнөх оноос дамжиж ирсэн төсөл, арга хэмжээ байна. Үүнд,

- ✦ Булган, Дорнод аймгийн ЗДТГ-ын барилгууд нь 2011, ТЗҮААЭГ-ын автобаазын барилга 2012 оноос дамжин ирсэн бөгөөд зураг төсөвгүй батлагдсан;
- ✦ Архангай аймгийн Хашаат сумын ЗДТГ-ын барилга нь зураг төсөвгүй;
- ✦ Хэнтий аймгийн Биндэр, Өмнөдэлгэр сумдын ЗДТГ-ын их засварын ажлууд нь зураг төсөв, тооцоо судалгаагүй;
- ✦ Дорноговь аймгийн ЗДТГ, сургууль, цэцэрлэгийн цэвэр, бохир усны шугамыг шинэчлэн солих ажил нь зураг төсөвгүй;
- ✦ Төрийн ордны зүүн жигүүрийн 2 дугаар давхарын албан ажлын өрөөг тохижуулахад 570.0 сая төгрөг төлөвлөсөн ч тооцоо судалгаагүй байсан байна.

Төсвийн тухай хуульд ТЭЗҮ, зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээ, барилга байгууламж батлагдсаар байна

1.25 2013 оны төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад “Төсвийн тухай хууль”-ийн 29.4¹, “Барилгын тухай хууль”-ийн 15.2², “Барилгын тухай” хуулийн 15.1.1³ дах заалтуудыг зөрчин ТЭЗҮ, зураг төсөвгүй, техникийн өхцөл бүрэн бус төсөл, арга хэмжээ, барилга байгууламж цөөнгүй тусгагдсан байна. Тухайлбал,

ХЗС-ын багцад

- ✦ “Дүүргийн прокурорын нэгдсэн байр (УБ.ХУД)-ны барилгыг 10,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2013 онд санхүүжих дүн 4,000.0 сая;
- ✦ “Дүүргийн шүүхийн нэгдсэн байр (УБ.ХУД)-ны барилгыг 15,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2013 онд санхүүжих дүн 6,000.0 сая;

БШУС-ын багцад

- ✦ Сэлэнгэ аймгийн Баруунбэрэн сумын 750.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй спорт заалны барилга, 2013 онд санхүүжих дүн 488.0 сая;
- ✦ Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 750.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 75 ортой цэцэрлэгийн барилга, 2013 онд санхүүжих дүн 600.0 сая;
- ✦ Төв аймгийн Эрдэнэсант сумын 1,300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 150 хүүхдийн дотуур байрны барилга, 2013 онд санхүүжих дүн 700.0 сая;
- ✦ Төв аймгийн Баянцогт сумын сургуулийн 70.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй засварын ажил, 2013 онд санхүүжих дүн 70.0 сая;
- ✦ Төв аймгийн Лүн сумын 70.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 320 сурагчтай сургуулийн барилгын засварын ажил, 2013 онд санхүүжих дүн 70.0 сая;
- ✦ Шинжлэх ухааны судалгааны лаборатори, спортын танхим бүхий 4,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цогцолборын барилга (Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг), 2013 онд санхүүжих дүн 1,000.0 сая;
- ✦ Дундговь аймаг 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй газар хөдлөлтийг бүртгэх станцын барилга, 2013 онд санхүүжих дүн 300.0 сая

ССАЖС-ын багцад

- ✦ Өмнөговь аймгийн Гурван тэс сумын 720.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй соёлын төвийн барилга, 2013 онд санхүүжих дүн 720.0 сая;
- ✦ Дорнод аймгийн Баяндун сумын 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Буриадын өв” соёлын төвийн барилга, 2013 онд санхүүжих дүн 100.0 сая;

УУС-ын багцад

- ✦ Сонгинохайрхан дүүрэгт баригдсан Газрын тосны чанарын хяналтын лабораторийн барилга 840.0 сая;

ШС-ын багцад

- ✦ МХЕГ-ын Төв аймгийн Зуунмод хотод баригдаж буй лабораторийн барилга, Дархан-Уул, Архангай, Говь-Алтай, Сэлэнгэ аймгийн Мандал сум, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум, Хэнтий аймгийн Бэрх тосгоны гал унтраах ангийн барилгууд, УБ хотын улсын нөөцийн “Объект-03” салбарын иж бүрэн агуулахын барилга;

ЭМС-ын багцад

- ✦ Архангай аймгийн Тариат суманд баригдах 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хүн эмнэлгийн барилга;
- ✦ Өмнөговь аймгийн Даланзадгад хотод баригдах 2,657.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Говийн бүсийн эмчилгээ оношлогооны барилга;

НЗДТГ-т

- ✦ Нийслэлд эрх шилжсэн 13 төсөл, арга хэмжээний 16.3 хувь буюу 12,946.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл, арга хэмжээ тус тус зураг төсөвгүй

¹ “Төсвийн тухай хууль”-ийн 29.4¹: Хөрөнгө оруулалтын төсөвт ТЭЗҮ хийгдсэн, зураг төсөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

² “Барилгын тухай хууль”-ийн 15.2²-т: Зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахыг хориглоно

³ Барилгын тухай” хуулийн 15.1.1³-д. “Барилга байгууламж барих газрын зөвшөөрөл авах, техникийн нөхцөл бүрдүүлэх, зураг төсөл захиалах”,

батлагдсан байна.

1.26 Мөн 2013 оны өсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, техникийн нөхцөл бүрэн шийдэгдээгүй дараах барилга байгууламжийг барихаар тусгажээ. Тухайлбал,

ХЗС-ын багцад

- ✚ “Дүүргийн прокурорын нэгдсэн байр (УБ.ХУД)-ны барилгыг 10,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2013 онд 4,000.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 2013-2014 онд ашиглалтад оруулахаар;
- ✚ “Дүүргийн шүүхийн нэгдсэн байр (УБ.ХУД)-ны барилгыг 15,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2013 онд 6,000.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 2013-2014 онд ашиглалтад оруулахаар техникийн нөхцөл бүрэн шийдэгдээгүй байхад;
- ✚ НЗДТГ-т эрх шилжсэн нийт төсөл, арга хэмжээний 10.3 хувь буюу 42,511.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл, арга хэмжээ газар олголт болон өлөөлөлт, техникийн нөхцөл шийдэгдээгүй байхад баталжээ.

1.27 2013 оны өсвийн тухай хуулинд батлагдсан төсөл, арга хэмжээ, барилга байгууламж нь тухайн хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр өөр багцад шилжсэн тохиолдол байна. Тухайлбал,

БХБС-ын багцад

- ✚ ҮХААС-ын багцад хэрэгжүүлэх “Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор болон Багануур УТП -ийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах 1,000.0 сая;
- ✚ ЭХС-ын багцад хэрэгжүүлэх “Шинэ Яармаг хорооллын 110/35/10 кВ-ын 2х40 МВА чадалтай компьютерийн хяналт удирдлагын системийн дэд станцын зураг, төслийг боловсруулах (УБ) 350.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ байна.

1.28 Улсын хэмжээний дунд хугацааны хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлог о, хөтөлбөрийг оновчтой боловсруулж, тэрчлэн ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээний жагсаалтыг гаргаж, санхүүжилтийн бүх эх үүсвэрийг хамруулан, цогц байдлаар тооцож, ТЭЗҮ, зураг төсөв нь баталгаажсан төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлж байх шаардлагатай байна.

Бүлэг 2 Худалдан авах ажиллагаанд гарч байсан өмнөх онуудын зөрчил арилаагүй байна.

Ерөнхий мэдээлэл

2.1 ТБОНӨХБАҮХАТХ-ийн 48.4-т “Төсвийн ерөнхийлөн захирагч болон худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах бараа, үйлчилгээний нэгдсэн төлөвлөгөөг баталж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж баталсан байна.

2.2 Мөн дээрх хуулийн 48.5-д “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэж заажээ.

2.3 ТБОНӨХБАҮХАТХ-ийн 45.5-д “Тухайн төсвийн жилд худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын хэрэгжих улсын болон бүс нутгийн чанартай төсөл, арга хэмжээний жагсаалтыг улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 5 өдрийн дотор Засгийн газар батална” гэж заасан байна.

Нийт тендер шалгаруулалтын 66.7 хувийг нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулжээ

2.4 Засгийн газар 2012 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 131 дүгээр тогтоолоор “Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын 2013 онд хүрээж төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг баталжээ.

2.5 Дээрх жагсаалтад 399 төсөл, арга хэмжээг ХААГ-аас зохион байгуулахаар баталсан бөгөөд Засгийн газрын 8 удаагийн тогтоолоор 67 төсөл, арга хэмжээг хасч, 2 арга хэмжээг нэмсэн байна.

2.6 Улсын хэмжээнд 2013 онд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 724 төсөл, арга хэмжээ буюу 66.7 хувь, харьцуулалтын аргаар 224 төсөл, арга хэмжээ буюу 20.7 хувь, гэрээ шууд байгуулах аргаар 122 төсөл, арга хэмжээ буюу 11.3 хувь, хязгаарлагдмал тендер шалгаруулалтаар 14 төсөл, арга хэмжээ буюу 1.3 хувь, нийт 1084 төсөл, арга хэмжээний худалдан авах арга хэмжээг зохион байгуулжээ.



2.7 2013 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг графикаар харуулбал,

2.8 Төсвийн тухай хуулиар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх эрхийг орон нутагт өгснөөр сумдад худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан цахим хуудаст тендерийн урилга, үр дүнг нийтлэх эрхийг 180 байгууллагад нэмж олгосон нь өмнөх онтой харьцуулахад 55.7 хувиар өсчээ.

2.9 Засгийн газрын худалдан авах ажиллагааны (*e-procurement.mn*) цахим хуудаст нийт 503 байгууллага нэвтрэх эрх авч, 3826 тендерийн урилга зарлагдаж, 2083 тендер шалгаруулалтын үр дүн⁴ нийтлэгдэж, 132 тендер үчингүй болсон байна.

2.10 Эндээс харахад тендерийн урилгыг олон нийтэд зарлан мэдээлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулж байгаа боловч үр дүнг мэдээлэх талаар хангалтгүй ажиллаж байна. Ганцхан жишээ авч үзэхэд,

✚ БШУС-ын багцын 2013 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөө, түүний үр дүнг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим үйлчилгээнд байршуулаагүй байгаа нь СС-ын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан “ТБОНӨХБАУХА ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.10⁵ дах заалтыг зөрчсөн байна.

2.11 Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газарт ТБОНӨХБАУХАТХ-ийн 49.7⁶-д заасны дагуу ТЕЗ-ын ирүүлсэн 2013 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, худалдан авах ажиллагааны хяналт - шинжилгээ, үнэлгээний системд нийтэлсэн төлөвлөгөө, тендер шалгаруулалтын явц, цахим сүлжээнд нийтлэгдсэн тендер шалгаруулалтын урилга, үр дүн болон гомдлын судалгаанд үндэслэн худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ өгсөн байна.

2.12 ТЕЗ нарын 2013 оны худалдан авах ажиллагаанд өгсөн үнэлгээний дүнгээс үзэхэд 5 төсвийн ерөнхийлөн захирагч 80-87 оноо буюу “сайн”, 11 төсвийн ерөнхийлөн захирагч 60-79 оноо буюу “хангалттай”, 8 төсвийн ерөнхийлөн захирагч 40-59 оноо буюу “хангалтгүй”, 2 төсвийн ерөнхийлөн захирагч “муу” үнэлгээ авсан бөгөөд 6 төсвийн ерөнхийлөн захирагч тайлан огт ирүүлээгүй байна.

2.13 ТЕЗ нарын худалдан авах ажиллагаанд өгсөн үнэлгээг сүүлийн 5 жилийн байдлаар харуулбал,

№	ТЕЗ	Оноор (үнэлгээ) хувиар					
		2008	2009	2010	2011	2012	2013
1	БОНХС	34	9	0	61	76	74
2	БХБС	65	42	56	60	55	51
3	ЗТС					71	48
4	БХС	71	80	80	58	64	62
5	БШУС	67	54	60	60	0	0
6	ГХС	46	0	40	41	62	68
7	СС	64	60	69	64	55	-
8	ССАЖС					0	0
9	ҮХААС	60	61	66	63	64	67
10	ХС	76	65	61	84	38	60
11	ХАХНХС					49	53
12	ХЗС	49	60	60	61	73	75
13	ЭЗХС					56	60

⁴ Сангийн яамны худалдан авах ажиллагааны тайлан

⁵ СС-ын 2012 оны 264 дугаар тушаалаар баталсан “ТБОНӨХБАУХА ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.10-т “Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэс захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ирүүлсэн даруйд Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас (www.e-procurement.mn)-т байрлуулна

⁶ ТБОНӨХБАУХАТХ-ийн 49.7-д Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 49.5 дахь хэсэгт заасны дагуу ирүүлсэн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн дүгнэж, дараа жилийн эхний улиралд Засгийн газарт тайлагнана.

14	ЭМС	86	45	61	0	65	31
15	ЭХС	71	51	56	58	76	51
16	УУС					54	60
17	АТГ	62	58	60	80	71	69
18	ЕТГ	-	-	64	60	51	-
19	ЗГХЭГ	60	65	63	64	60	86
20	ЕС	78	61	67	75	78	63
21	СЕХ	60	70			60	47
22	ТАЗ	92	0		96	67	-
23	ЦАУЗБУК						83
24	УДШ	92	0	69	74	63	80
25	УЕП	80	100	85	0	56	56
26	ҮХЦ	85	93	100	80	96	76
27	ҮАБЗ					85	-
28	ҮСХ	70	72	57	97	80	87
29	ХЭҮК	76	0	94		45	46
30	ШС	0	75	60	0	33	48
31	ШЕЗ	85	86	89	62	100	80
ДУНДАЖ		50.7	41.6	47.3	42.9	57.5	62

* Эх сурвалж Сангийн яамны худалдан авах ажиллагааны 2013 оны тайлан

2.14 Дээрх судалгаанаас харахад худалдан авах ажиллагааны хэрэгжилт, зохион байгуулалтад өгсөн үнэлгээний дундаж өмнөх оноос 5.5 пунктээр өсчээ.

2.15 2013 онд ШӨХТГ -т худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүйтэй холбоотой 21 гомдол ирсний 7-г үндэслэлтэй гэж үзэн тендер шалгаруулалтыг дахин явуулах, 9 гомдлыг холбогдох байгууллагад хандах, 5 гомдол хууль зөрчөөгүй талаар шийдвэр гаргаж хариуг хүргүүлжээ.

2.16 2013 онд Сангийн яаманд ТБОНӨХБАҮХАТХ -ийн 55.1 дэх хэсэгт заасны дагуу худалдан авах ажиллагаатай холбоотой 299 гомдол ирүүлсний 35.5 хувь нь хуульд нийцээгүй тул тендер шалгаруулалтыг дахин явуулах, 22 хувийг үжингүй болгох шийдвэр гаргасан байна.

Худалдан авах ажиллагааны аргыг буруу сонгосон зөрчил гарч байна

2.17 Зураг, өсөв баталгаажуулахгүй байхад худалдан авах ажиллагааг зохион байгуулсан зөрчил, дутагдал гарсаар байна. Тухайлбал,

- ✚ Архангай аймгийн ОБХ-ийн Аврах, гал унтраах ангийн барилгын зураг, төсөвт БХТ -өөс 2013 оны 10 дугаар сарын 16-нд магадлал хийсэн байхад БУА гүйцэтгэх гэрээг 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр байгуулсан;
- ✚ Говь-Алтай аймгийн Булбулаг сумын Аврах, гал унтраах ангийн барилгын зураг төсөвт БХТ-өөс 2013 оны 12 дугаар сарын 16-нд магадлал хийсэн байхад БУА гүйцэтгэх гэрээг “Ганзосон констракшн” ХХК -тай 2013 оны 8 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан;
- ✚ Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Аврах, гал унтраах ангийн барилгын зураг төсөвт БХТ-өөс 2013 оны 10 дугаар сарын 16-нд магадлал хийсэн байхад БУА гүйцэтгэх гэрээг “Зос трэйд” ХХК-тай 2013 оны 7 дугаар сарын 8-ны өдөр байгуулсан;
- ✚ Хэнтий аймгийн Бэрх тосгонд баригдах Аврах, гал унтраах ангийн барилгын зураг төсөвт БХТ-өөс 2013 оны 10 дугаар сарын 16-нд магадлал хийсэн байхад БУА гүйцэтгэх гэрээг “Нью констракшн” ХХК-тай 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр байгуулсан;
- ✚ Сэлэнгэ аймгийн Мандал сумын Аврах, гал унтраах 19-дээр ангийн барилгын зураг төсөвт БХТ-өөс 2013 оны 12 дугаар сарын 16-нд магадлал хийсэн байхад БУА гүйцэтгэх гэрээг 2013 оны 8 дугаар сарын 12-ны өдөр тус тус байгуулсан байна.

2.18 БХБС-ын багцад аймаг орон нутагт он дамжин хэрэгжиж байгаа зарим ажлыг дотор нь хэд хэдэн багц болгон задалж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан боловч, багц тус бүрийн ажлын гүйцэтгэл харилцан адилгүй байна. Үүнд,

- ✚ Аймаг, орон нутгийн инженерийн шугам өлжээ (21 аймаг, сумдад) төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 11 багц болгон задалж зарласнаас 7 багцтайг гэрээ шалгарч, гэрээ байгуулах явц оройтсоноос 5 багц арга хэмжээ нь 2014 онд гэрээлжлэхээр хойшилсон;
- ✚ 4 багц ажлын гүйцэтгэгчээ шалгаруулж чадаагүй байна.

2.19 ЭМС-ын багцад 9,312.6 сая төгрөгийн 10 тоног төхөөрөмж худалдан авахаар баталсан боловч 7 төсөл, арга хэмжээнд урьдчилсан үнийн судалгаа хийгдээгүй, техникийн үзүүлэлтийг тодорхойлоогүй, ямар тоног төхөөрөмж худалдан авахыг эцэслэн тогтоогоогүй байна. Үүнд,

Худалдан авалтын задаргаа нь бэлэн болоогүй:

- ✚ Арьсны өвчин судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмж худалдан авах 700.0 сая;
- ✚ Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн шим тэжээл, хор судлал, биотехнологийн үндэсний үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж худалдан авах 2,000.0 сая;
- ✚ Яаралтай түргэн тусламжийн төвийн 600.0 сая, нийт 3,300.0 сая төгрөг.

Үнийн судалгаа хийгдээгүй:

- ✚ Байгалийн голомтот халдварт өвчин судлалын төвийн 1,420.6 сая;
- ✚ Сум дундын эмнэлгүүдэд тоног төхөөрөмж худалдан авах 1,000.0 сая;
- ✚ Анхан шатны эмнэлгүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах 1,000.0 сая. нийт 3,420.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авах төсөл арга хэмжээний үнийн судалгааг тус тус хийгээгүй байна.

2.20 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх төсөл, арга хэмжээн ий худалдан авах ажиллагаа хуулийн хугацаандаа эхлэхгүй байх, шалгаруулалтын шийдвэрт гомдол гарах, гэрээ байгуулахаас татгалздагаас төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах нөхцөлийг бий болгож байна.

2.21 Захиалагчид ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6.1⁷, 21.4⁸ дэх заалтуудыг баримталж ажиллаагүй нь худалдан авах ажиллагааны аргыг буруу сонгох, үнэлгээ буруу хийгддэг зэрэг хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд сөрөг үр дагавартай байна.

2.22 ЭЗХС-ын багцад “Улсын хэмжээнд 2014-2015 онд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах” ажлын 5,788.1 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулах аргыг ашигласан нь Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 68 дугаар тогтоол⁹-оор батлагдсан босго үнийг мөрдөөгүй байна. Тухайлбал,

- ✚ ЗГХЭГ-аас ТЗҮААЭГ-ийн автобаазын парк шинэчлэлийг хийхээр батлагдсан 1,000.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг 2 багц болгон худалдан авах ажиллагааг нээлттэй зарласан ч 2 дах багцад техникийн үзүүлэлтийг хангасан тендерийн санал ирээгүйгээс

⁷ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6.1-д худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлана

⁸ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 21.4-т заасны дагуу захиалагч цахим хуудаст тендерийн урилгыг нийтэлж, шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлж байх ёстой

⁹ Засгийн газрын 68 дугаар тогтоолоор батлагдсан ТБОНӨХБАҮХАА-нд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ

гэрээ шууд байгуулах аргыг ашиглажээ.

- ✦ Тус багцын хүрээнд Төрийн ордны хоёр давхрын албан ажлын өрөөг тохижуулах ажлыг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3.4¹⁰-т заасныгүндэслэн гэрээ шууд байгуулах аргыг сонгосон байна.

2.23 ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 4¹¹, 5¹² дэх заалтыг зөрчиж, худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа өвчт өртгөөр бус хэсэгчилсэн байдлаар тендер зарлаж байна. Тухайлбал,

- ✦ Хэнтий аймгийн Мөрөн сумын цэцэрлэгийн барилга, Хэнтий аймгийн Баянмөнх сумын дотуур байр, Хэнтий аймгийн Галшар сумын цэцэрлэгийн барилга, Дорнод аймгийн Хэрлэн сумын 6-р сургуулийн спорт заал, Дорнод аймгийн Дашбалбар сумын сургуулийн спорт заал, Дорнод аймгийн Матад сумын сургуулийн спорт заал, Дорнод аймгийн Жлөнбуйр сумын 75 ортой цэцэрлэг, Дорнод аймгийн Жлөнбуйр сумын спорт заал, Дорнод аймгийн Хэрлэн сумын хоёрдугаар багийн спорт заалны барилга;
- ✦ Нисэхийн товчоо-Биокомбинат-Шувуун фабрик чиглэлийн 22.5 км авто замын өргөтгөл шинэчлэлт”;
- ✦ “СХД-ийн 2, 3, 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах 2 км хатуу хучилттай авто замын барилга”;
- ✦ “Доржийн гудамж, Туул жин пангийн уулзвараасүүн тийш -Цайз зах хүртэлх 2.8 км авто замын өргөтгөл шинэчлэлт”;

2.24 Орон нутагт худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тендерийн материал нь дутуу, тусгай зөвшөөрөлгүй аж а хуйн нэгжийг үйцэтгэгчээр сонгон шалгаруулсан байна. Тухайлбал,

- ✦ Сэлэнгэ аймгийн Фхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн барилгын их засварын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Нүнжиг” ХХК нь тендерийн баримт бичигт заасан зарим төрлийн тусгай зөвшөөрөлгүй, туслан үйцэтгэгч “Шинэ дээвэр” ХХК -иас холбогдох баримт, өргүйг нотолсон тодорхойлолт, машин механизм, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, ижил төстэй хийж гүйцэтгэсэн барилгын ажлын гэрээ, хүлээлгэн өгсөн ажлын улсын комиссын актын нотариатаар баталгаажуулсан хуулбар ирүүлээгүй;
- ✦ Мөн тус аймгийн Мандал сумын 1-р цэцэрлэгийн засварын ажлын үйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгохдоо барилгын ажил эрхлэх тусгай зөвшөөрөлгүй “Цацрах тал” ХХК-д урилга илгээж, гүйцэтгэгчээр шалгаруулсан;
- ✦ Хөвсгөл аймгийн ЗДТГ-аас аймгийн МСҮТ-ийн авто засварын дадлагын газар барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцсон “Эндус Эрхэт” ХХК-ний ирүүлсэн тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа хангалтгүй байхад шалгаруулсан;
- ✦ Архангай аймгийн МӨТ -ийн дотуур байрны барилгын засварын ажлын үйцэтгэгчээр “Цагаан сүмбэр” ХХК шалгарсан гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй байхад шалгаруулсан;
- ✦ Төв аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан Заамар сум дахь МСҮТ-ийн хичээлийн байрны 56.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй засварын ажлын гүйцэтгэгч чийг сонгон шалгаруулах тендерт шаардлагад нийцсэн тендер ирээгүйгээс дахин тендер зарлан хугацаа алдаж, улмаар ЗГ-ын 2013 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 324 дүгээр тогтоолд хамрагдсан;

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад 200-398 хоног зарцуулж байна

¹⁰ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3.4-т “төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй”

¹¹ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 4-т “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”

¹²ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”;

2.25 ЗГХЭГ-ын даргын 2013 оны 6 дугаар сарын 13-ны 101 үдээр тушаалаар шинэчлэлийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг ХААГ-т шилжүүлсэн байна.

2.26 Ерөнхий сайдын багцын хүрээнд “Шинэчлэлийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалт”-ын 7 өсөл, арга хэмжээг 2 5 багцад хуваан худалдан авах ажиллагааг 2013 оны 7 дугаар сарын 10-наас 12 дугаар сарын 24-ны хооронд зохион байгуулжээ. Үүнд,

- ✦ “Иргэдэд шаардлагатай лавлагаа, мэдээлэл өгөх автомат машинуудыг байрлуулах” ажлын хүрээнд 120 автомат киоск машинуудыг УБ хотод болон 21 аймгийн өвд байрлуулах төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгаруулах тендерийг 2013 оны 6 дугаар сарын 21 - ний өдөр зарлаж 2 компани материал ирүүлснээс “Нью соник” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн боловч татгалзсан байна. Дахин тендер зарлаж “Ай Ти Зон” ХХК-д 2013 оны 11 дүгээр сарын 25 -нд гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн боловч тендер шалгаруулалтын шийдвэрт гомдол гарч С Я тендерийн материалыг хянаж байх явцад тендерийн хүчинтэй хугацаа дууссан учир гэрээ байгуулах боломжгүй болсон.
- ✦ “Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй шуурхай болгох” төсөл, арга хэмжээний 5 багцаас хот хоорондын шуудан тээвэр, хүргэлтийн автомашин нийлүүлэхээс бусад багцад ХААГ-ын даргын 2013 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн А/303 дугаар тушаалаар батлагдсан үнэлгээний хороо НТШ -ын журмаар 2 удаа тендер зарласан боловч шаардлагад нийцсэн тендер ирээгүй учраас гэрээ шууд байгуулах аргын дагуу гүйцэтгэгчийг сонгосон байна.
- ✦ “Замын цагдаагийн торгуулийг бэлнээр гөлдө гүй, тасалбарын систем нэвтрүүлэх”-тэй холбоотой гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад 5 компани оролцож, “Смарт солюшн” ХХК шалгарч 1,800.7 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.
- ✦ “Аймгийн төвүүдэд битүү зах, худалдааны төв барих” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгаруулах үнэлгээнд гомдол гарсан тул шалгагдаж байгаа.
- ✦ “Аймгуудад нэгдсэн оношлогооны төв бий болгох” төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны гүйцэтгэгч шалгаруулалтад 2 удаа гомдол гарсан учраас шалгагдаж байгаа.
- ✦ “Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд хөрөнгө оруулалт хийх” төсөл, арга хэмжээг 2 багцад хуваан 2013 оны 7 дугаар сарын 10-ны өдөр тендерийг нээлттэй зарлаж, “Цагаан зуун” ХХК гадна спорт талбайн цогцолборын ажлын гүйцэтгэгчээр шалгарч, 2013 оны 8 дугаар сарын 30-ны өдөр ажил гүйцэтгэх 1,429.0 сая төгрөгийн гэрээг 60 хоногийн хугацаанд гүйцэтгэхээр байгуулсан;
-2.655 км урт дугуй, цана, гүйлтийн хосолсон зам болон дугуйн зогсоол, гэрэлтүүлэг хийх багцын гүйцэтгэгчээр “Бүрд констракшн” ХХК шалгарч 2013 оны 8 дугаар сарын 30-нд 3,717.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан;
- ✦ Залуучуудын үйлчилгээний цогцолбор босгох” төсөл, арга хэмжээнд “Хаш ган эрдэнэ” ХХК-д түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр 1,762.2 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

2.27 Худалдан авах ажиллагааг сүүлийн хагас жилд зохион байгуулж байгаа нь хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж, хугацаа алдах, хөрөнгийг буцаан татуулахгүйн тулд шаардлагад нийцэхгүй гүйцэтгэгч сонгох, он дамжих, хуурамч гүйцэтгэлээр санхүүжилт олгоход хүргэж байна. Тухайлбал,

- ✦ ЭЗХС-ын багцад зарлагдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг хугацаагаар тооцоход 2013 оны сүүлийн хагас жилд 65.1 хувийг байгуулсан;
- ✦ ЗГХЭГ-аас Архангай аймгийн нэгдсэн эмнэлгийн оношлогооны төвийн засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг 2013 оны 11 дүгээр сард;
- ✦ БШУЯ-наас Архангай аймгийн Хайрхан сумын сургуулийн спорт заалны засвар, Өндөр - Улаан сумын сургуулийн спорт заалны засвар, халаалтын тогооны шинэчлэлийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг 2013 оны 11 дүгээр сард;
- ✦ ЭХС-ын багцад гэрээ байгуулах эрх олгогдсноос хойш 30 хоногийн дараа 2 ажилд гэрээ байгуулсан нь ажил удаашрах, он дамжин хэрэгжихэд хүргэсэн;

✚ *ЕС-ын багцын “Шинэчлэлийн жетөлбөрийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”-ний гүйцэтгэгчтэй 7-12 дугаар сард гэрээ байгуулсан байна.*

2.28 Нийслэлд эрх нь шилжсэн улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд зарцуулсан хугацааг хууль батлагдсанаас хойш дуусах үе шат бүрээр авч үзвэл,

- ✚ *2013 оны төсвийн тухай хууль батлагдсанаас хойш яамдын сайд болон бусад эрх бүхий ТЕЗ-аас нийслэлийн Засаг даргад эрх шилжиж ирэхэд 34-281 хоног, дундажаар 167 хоног;*
- ✚ *Нийслэлийн Засаг даргаас нийслэлийн ХААГ-т болон харьяа газруудад эрх шилжүүлэхэд 14-165 хоног, дундажаар 48 хоног;*
- ✚ *Тендерийн үнэлгээний хороо байгуулах захирамж гарахад 2-51 хоног, дундажаар 12 хоног;*
- ✚ *Тендерийн үнэлгээний хороог байгуулсан захирамж гарснаас хойш тендерийг зарлахад 5-222 хоног, дундажаар 26 хоног;*
- ✚ *Тендер зарласнаас хойш үнэлгээний хорооноос гэрээ байгуулах зөвлөмж гаргахад 4-221 хоног, дундажаар 37 хоног тус тус зарцуулжээ.*

2.29 Үүнээс үзэхэд худалдан авах ажиллагаанд зарцуулсан хугацааны 57.0 хувийг яамдын сайд болон бусад эрх бүхий захиалагчдаас нийслэлийн Засаг даргад эрх шилжүүлэхэд, 17.0 хувийг нийслэлийн Засаг даргаас ХААГ болон бусад харьяа газруудад эрх шилжүүлэхэд, 4.0 хувийг тендерийн үнэлгээний хороог байгуулахад, 22.0 хувийг худалдан авах ажиллагааг зохион байгуулахад тус тус зарцуулжээ.

2.30 Хууль батлагдсанаас хойш үнэлгээний хорооны зөвлөмж гарах хүртэл 200-398 хоног зарцуулж байгаагийн 78.0 хувийг үнэлгээний хороо байгуулах хүртэлх ажиллагаанд зарцуулсан байна.

2.31 Энэ бүхнээс үзэхэд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ удаашрах нэг нөхцөл нь худалдан авах ажиллагааг зохион байгуулахад хугацаа алдаж байгаатай холбоотой байна.

Бүлэг 3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Ерөнхий мэдээлэл

3.1 2013 оны төсвийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 972 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд ТЕЗ-ын багцын хүрээнд 2522 төсөл, арга хэмжээ болж задарсан байна.

3.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2013 онд 787.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийснээр төлөвлөгөөний биелэлт 70.1 хувьтай байна.

3.3 Улсын төсвийн хөрөнгөөр 2009-2013 онд санхүүжигдэн ашиглалтад орсон барилга байгууламж, дэд бүтцийг дараах хүснэгтэд харуулав.

Үзүүлэлт	Х/н	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он
Нийт хөрөнгө оруулалт	тэрбум төгрөг	374.6	473.2	901.4	1,119.5	787.8
Хатуу хучилттай авто зам	км	119.9	274.2	334.6	151.1	336.3
Хайрган хучилттай авто зам	км	40.1	56.5	0.0	0.0	0.0
Төмөр бетон гүүр	у/м	498.2	602.3	374.1	545.1	320.1
Эрчим хүчний шугамд холбогдсон сум	тоо	19	17	6	5	11
Ашиглалтад орсон ЦДШ	км	1 091.0	1 121.0	459.3	742.7	636.2
Ашиглалтад орсон ЕБС	суудлын тоо	5 900	4 668	5 880	11558	6248
Ашиглалтад орсон цэцэрлэг	орны тоо	1 825	2 460	3 270	3200	2150
Ашиглалтад орсон соёлын төв	суудлын тоо	3 889	2 890	1 780	1890	1250
Сургуулийн дотуур байр	орны тоо	1 089	1 045	930	930	1430
Сургуулийн спорт заал	м ²	3 870.0	2 016.0	3000.0	2718	3718
Ашиглалтад орсон хүн эмнэлэг	тоо	14	18	16	15	12
Ашиглалтад орсон хүн эмнэлэг	орны тоо	285	325	310	200	270
Инженерийн хийцтэй худаг	тоо	252	258	652	463	415
Услалтын систем	га	3 733.2	3 155.0	1531.1	1302.1	1048

*Эх сурвалж: Сангийн яамны хөрөнгө оруулалтын хэлтэс

3.4 Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламж дараах шалтгааны улмаас хэрэгжээгүй байна. Тухайлбал,

- Тендер оройтож хуулийн хугацаанд нь зарлаагүй, шаардлага хангасан тендер ирээгүй, тендерт шалгарсан боловч гэрээ байгуулахаас татгалзсанаас шалтгаалан 41,044.2 сая өгрөгийн 33 арга хэмжээ, барилга байгууламж хэрэгжээгүй байна. Үүнд:

- ✚ ШС-ын багцын хүрээнд ШӨХТГ-т 258.4 сая төгрөгийн 2;
- ✚ БШУС-ын багцын хүрээнд 7,991.8 сая төгрөгийн 22;
- ✚ ССАЖС-ын багцад 19,274.0 сая төгрөгийн 4;
- ✚ ХС-ын багцад 3,000.0 сая төгрөгийн 1;
- ✚ ЗТС-ын багцад 2,520.0 сая төгрөгийн 1;
- ✚ БХБС-ын багцад 8,000.0 сая төгрөг ийн 3 төсөл, арга хэмжээ, барилга байгууламж хэрэгжээгүй байна.

- Ерөнхий сайдын багцын хүрээнд “Шинэчлэлийн өгөлбөрийн хөрөнгө оруулалт”-аар хэрэгжүүлэх 7 төсөл, арга хэмжээнээс хэрэгжээгүй 3 багц байгаа бөгөөд бусад нь хэрэгжилтийн шатандаа байна. Үүнд,

- ✦ Иргэдэд шаардлагатай лавлагаа, мэдээлэл автоматаар машинуудыг байрлуулах төсөл, арга хэмжээ (120 автомат киоск машинуудыг УБ хот болон 21 аймгийн өвд байрлуулах) 2,000.0 сая төгрөгийн 1;
- ✦ Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй шуурхай болгох төсөл, арга хэмжээний багц-3 (Шуудан хүргэгч нарт гар компьютер худалдан авч өгөх) 150.0 сая төгрөгийн 1;
- ✦ Улаанбаатар хотод эх, ураг, нярайн тусламж үйлчилгээний төв байгуулах төсөл, арга хэмжээний багц-3 (тусламж үйлчилгээний орчин бүрдүүлэх, засвар тохижилтын ажил, катетерийн лаборатори байгуулах) 2,420.1 сая төгрөгийн 1.

- Гүйцэтгэгч байгууллагын ажиллах хүч, техник хангамж дутагдсан болон ажлын зохион байгуулалт хангалгүйгээс гэрээнд заасан хугацаанд 12,005.2 сая төгрөгийн 22 төсөл, арга хэмжээ, барилга байгууламж хэрэгжээгүй байна. Үүнд:

- ✦ ССАЖС-ын багцад 2,864.3 сая төгрөгийн 3;
- ✦ УХААС-ын багцад 132.6 сая төгрөгийн 9;
- ✦ БШУС-ын багцад 9,008.3 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ тус тус хэрэгжээгүй.

3.5 2013 оны өсвийн тухай хуулиар батлагдсан төсөл, арга хэмжээ , барилга байгууламжийн зориулалтыг өөрчилж хэрэгжүүлсэн байна. Тухайлбал,

УХААС-ын багцад

- ✦ 4,300.0 сая өгрөгийн төсөвт өртөгтэй хүнсний лавлагаа лабораторийг УБ хотод байгуулахаар баталсан боловч уг арга хэмжээ өрчилж, ШУТИС-ийн харьяа Үнсний инженер, биотехнологийн сургуулийн “Үнс судлалын эрдэм шинжи лгээний төв”-д хүнсний лабораторийн тоног төхөөрөмж худалдан авч суурилуулсан;
- ✦ Говь-Алтай аймгийн Баян-Уул, Дарви, Эрдэнэ сумдад шинээр худаг гаргахаар өсөв батлагдсан байхад сумдынүртгээлд байсан, ашиглалтгүй болсон 5 худгийг сэргээн засварласан;

3.6 2013 оны өсвийн тухай хуулиар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ , барилга байгууламжид батлагдсан хөрөнгөөс хөтөлбөр, урсгал зардалд зарцуулсан, дахин хөрөнгө төлөвлөсөн зөрчил гарсан байна. Тухайлбал,

- ✦ ССАЖС-ын багцад түүх, дурсгал, соёлын өвийг дэмжих болон сэргээн засварлахад 3,100.0 сая төгрөг зарцуулахаар батлагдаж, 1,618.6 сая төгрөгийн санхүүжилт авснаас түүх, дурсгалын газар, олдворыг авран хамгаалах ажлын урсгал зардалд 37.7 сая, усны сав, цахилгаан үүсгүүр, гагнуурын аппарат, контейнер худ алдан авахад 75.0 сая төгрөг зарцуулжээ.

Эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна

3.7 2013 онд улсын өсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх 178,766.1 сая өгрөгийн төсөвт өртөг бүхий 171 барилга байгууламж, төсөл, арга хэмжээ, 21,823.4 сая төгрөгийн 262 их засварын ажлыг хэрэгжүүлэх эрхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт шилжүүлжээ. Үүнд,

- ✦ БШУС-ын багцаас 14,872.5 сая төгрөгийн 27 барилга, байгууламж, 14,340.0 сая төгрөгийн 181 их засварын ажил;
- ✦ УХААС-ын багцаас 7,069.8 сая төгрөгийн 32 ажил;
- ✦ ХС-ын багцаас 1,940.8 сая төгрөгийн 14 арга хэмжээ;
- ✦ ССАЖС-ын багцаас 3,815.7 сая төгрөгийн 10 арга хэмжээ;
- ✦ ЗТС-ын багцаас 111,631.8 сая төгрөгийн 30 арга хэмжээ;

- ✦ ЕС-ын багцаас 1,980.0 сая төгрөгийн 11 арга хэмжээ;
- ✦ ЭЗХС-ын багцаас 180.0 сая төгрөгийн 1 арга хэмжээ;
- ✦ ШС-ын багцаас 806.0 сая төгрөгийн 15 их засварын ажил;
- ✦ ЗГХЭГ-ын багцаас 5,893.0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ;
- ✦ БОНХС-ын багцаас 413.2 сая төгрөгийн 26 төсөл, арга хэмжээ;
- ✦ БХБС-ын багцаас 30,862.3 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээ;
- ✦ ЭМС-ын багцаас 107.0 сая төгрөгийн 2 барилга, 6,677.4 сая төгрөгийн 66 их засварын ажил.

3.8 Аймаг, орон нутагт эрх шилжүүлсэн ажлын санхүүжилт, гүйцэтгэлд тавих хяналт сулаас хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал,

- ✦ Булган аймгийн Тэшиг сумын сургуулийн өргөтгөлийн барилгын тендерийг 2011 онд зарлаж 950.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчээр “Төмөр хүлэг” ХХК шалгарч гэрээ байгуулсан боловч ямар ажлыг гүйцэтгэж хэдий хэмжээний санхүүжилт авсан нь тодорхойгүй, барилгын ажлын гүйцэтгэл хангалтгүй;
- ✦ Булган аймгийн Булган суманд баригдаж байгаа 920.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 150 ортой цэцэрлэгийн барилгын ажлыг гүйцэтгэгчээр “Чин ван констракшн” ХХК шалгарч 800.0 сая төгрөгөөр 2012 оны 9 дүгээр сарын 3 -ны өдрөөс эхлэн 2013 оны 8 дугаар сарын 1-ний өдөр хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан боловч хугацаандаа ашиглалтад ороогүй;
- ✦ Булган аймгийн сумдад инженерийн хийцтэй худаг гаргах 122.3 сая төгрөгийн ажлыг “Газрын гүнийн ус” ХХК 2013 оны 7 дугаар сарын 8-наас 2013 оны 9 дүгээр сарын 11-ны дотор ашиглалтад үлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан боловч хугацаанаасаа 76 хоногоор,
- ✦ Архангай аймгийн сумдад инженерийн хийцтэй худаг гаргах 58.3 сая төгрөгийн ажлыг “Топ дриллинг” ХХК 2013 оны 7 дугаар сарын 15-наас 2013 оны 10 дугаар сарын 1-ны дотор ашиглалтад хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан боловч хугацаанаасаа 58;
- ✦ Ховд аймгийн сумдад инженерийн хийцтэй худаг гаргах 146.3 сая төгрөгийн ажлыг “Эвлэл” ХХК 2013 оны 5 дугаар сарын 30-наас 2013 оны 10 дугаар сарын 1-ны дотор ашиглалтад хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан боловч хугацаанаасаа 56;
- ✦ Хэнтий аймгийн сумдад инженерийн хийцтэй худаг гаргах 128.1 сая төгрөгийн ажлыг “Ус-онги” ХХК 2013 оны 5 дугаар сарын 13-наас 2013 оны 10 дугаар сарын 1-ний дотор ашиглалтад хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан боловч хугацаанаасаа 40;
- ✦ Сүхбаатар аймгийн сумдад инженерийн хийцтэй худаг гаргах 145.2 сая төгрөгийн ажлыг “Топ дриллинг” ХХК 2013 оны 6 дугаар сарын 1-нээс 2013 оны 10 дугаар сарын 30-ны дотор ашиглалтад хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан боловч хугацаанаасаа 34;
- ✦ Өмнөговь аймгийн ХХААЖДҮГ болон Мал эмнэлгийн лабораторийн 151.0 сая төгрөгийн засварын ажлыг “Говийн өгөөж” ХХК 2013 оны 6 дугаар сарын 24-нөөс 2013 оны 8 дугаар сарын 1-ны дотор ашиглалтад үлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан боловч хугацаанаасаа 63 хоногоор тус тус хэтрүүлсэн;
- ✦ Дорноговь аймгийн төвийн ЗДТГ, сургууль, цэцэрлэгийн цэвэр, бохир усны шугамыг шинэчлэн солих ажлыг ЗДТГ нь эрх шилжсэнийг мэдэвч гэсэн тайлбарыг өгч, Замын-Үүдэд хэрэгжүүлэхээр шийдсэн гэсэн ам яриатайгаар хэрэгжүүлээгүй байна.

3.9 Аймаг, орон нутагт эрх шилжсэн зам, гүүрийн ажлын 13 хэрэгжиж, 14 ажил 30-80 хувийн гүйцэтгэлтэй, 2 ажил тендер зарлагдаагүй, 1 ажил гэрээ байгуулах шатанд байна.

3.10 Мөн гүүрийн хийц, зураг төсвийг өөрчлөх, тендерт санал ирээгүй болон барилга угсралтын гэрээг оройтож байгуулснаас шалтгаалан дараах гүүрийн ажлууд хэрэгжээгүй байна. Үүнд,

- ✦ Увс аймгийн Ховд сумын Шивэрийн голын модон гүүр (Гэрээний дүн 4,000.0 сая);
- ✦ Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт орших Туул голын модон гүүрийн засвар (гэрээний дүн 1,000.0 сая);
- ✦ Увс аймгийн Тэс сумын Тэсийн голын 108 у/мөмөр бетон гүүр (Гэрээний дүн 3,000.0

сая);

3.11 ТЕЗ-ын зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан хугацаа нь Засгийн газрын 2013 оны 324¹³ дүгээр тогтоолын заалтыг зөрчсөн дутагдал цөөнгүй байна. Тухайлбал,

- ✦ **ЕС-ын багцад:** Шинэчлэлийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 17 багцын гүйцэтгэгчтэй 32,009.6 сая төгрөгийн гэрээ байгуулсан;
- ✦ **НХОГ** нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 6 гүйцэтгэгчтэй 2,850.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан.

3.12 ТЕЗ-аас гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний загварыг журмын дагуу бэлтгээгүй, шаардлагатай мэдээлэл, нөхцлүүдийг бүрэн тусгаагүй байна. Тухайлбал,

- ✦ ЭЗХЯ-наас нэг маягийн загвар зураг, өсөл боловсруулах улахаар “Зураг өсөл, эрдэм шинжилгээний институт” УТ -тай байгуулсан үндсэн гэрээнд ажил гүйцэтгэх хугацааг тусгаагүй;
- ✦ ССАЖЯ, БХБЯ, ҮХААЯ, ЭМЯ, БОНХЯ -ны гэрээний тусгай өхцөлд тогтоосон хугацаа “гэрээ байгуулсан өдрөөс эхлэнэ” гэсэн нь ажил эхлэх эсвэл дуусах хоёрын алин нь болох нь тодорхойгүй;
- ✦ “Дашинчилэн Орхоны гүүр чиглэлийн замын төгсгөлөөс Мөрөн-Тариалан чиглэлийн 79 км замын төгсгөлийг холбох авто замын зураг, төсөл боловсруулах гэрээ байгуулсан хугацаа байхгүй.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж он дамжин үргэлжилж байна

3.13 ТЕЗ-ын багцад өмнөх оноос шилжсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсвийг хугацаанд нь шийдээгүй, барилгын материалын үнэ өссөн, ЗТБХБС-ын (хуучнаар) 2012 оны 18, 181 дүгээр тушаалаар ба талсан барилгын норм дүрмийн дагуу зарим зардлууд нэмэгдсэн, гүйцэтгэгч шалгараагүйгээс удааширч ашиглалтад ороогүй объектууд цөөнгүй байна. Тухайлбал:

ЗГХЭГ-т

- ✦ Дорнод аймгийн ЗДТГ-ын барилгын зураг, төсвийг 2007 онд “ДОЗТ” ХХК 3,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр боловсруулж, 2011 оны 9 дүгээр сард худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчээр “Ган хийц” ХХК 3,198.5 сая төгрөгөөр шалгарсан байна. Тус компани 40.0 сая төгрөгийн санхүүжилт авч барилгын ажлыг эхлүүлсэн боловч 2012 онд захиалагчийн хариуцлагагүй ажиллагаанаас шалтгаалан улсын төсөвт тусгуулаагүй, 2013 онд 3,160.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан. Энэ хугацаанд цалин, барилгын материалын үнэ өсч төсөвт өртөг 6,962.0 сая төгрөг болсон;
- ✦ Булган аймгийн ЗДТГ-ын конторын барилгын зураг төсвийг 2011 онд “Өрх” ХХК 2,984.5 сая төгрөгийн хяналтын төсөвт өртөгтэйгээр боловсруулж, гүйцэтгэгчээр “Түмэн-Алт” ХХК 2,954.5 сая төгрөгөөр шалгарч, 2011 оны 9-р сарын 15-ны өдрөөс эхлэн 2012 оны 12 дугаар сард бүрэн дуусахаар гэрээ байгуулж, 2,277.8 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч дуусаагүй;
- ✦ ТЗҮААЭГ-ын автобаазын 400 автомашины гараашийн барилга 63.4x51.6 м хэмжээтэй, захиргааны барилга 20.67x 46.17 м хэмжээтэй зорь бхий 3 давхар 2 блок байхаар зураг төсвийг хийлгэсэн бөгөөд төсөвт өртөг нь 10,100.0 сая төгрөгөөр 2012 оны 8 сард экспертизээр батлагджээ. Гэвч улсын төсөвт зураг, төсөвгүйгээр 5,000.0 сая төгрөгийн дүнгээр тусгааснаас шалтгаалан барилгын ажлыг хэсэгчлэн, гараашийн ажил буюу нийт

¹³ Засгийн газрын 324 дүгээр тогтоолын "Хөрөнгө оруулалтын ажлыг 2013 онд багтаан гүйцэтгэх боломж, ажлын стандарт, чанарт тавигдах шаардлага зэргийг харгалзан 2013 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар гэрээ байгуулагдаагүй байгаа шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эхлэх хугацааг хойшлуулах"

талбайн 84.2 хувийг энэ төсөвт өртөгт багтаан “МВС” ХХК-тай 2012 оны 11-р сарын 1-нээс 2014 оны 7-р сарын 1-ны хооронд барьж дуусгахаар гэрээ байгуулжээ. Ажлын гүйцэтгэл 80.0 орчим хувьтай:

- ✦ Төрийн ёслол хүндэтгэлийн өргөөг олон нийтэд нээлттэй болгохоор Засгийн газраас шийдвэрлэснээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн явах зам, цахилгаан шатны шинэчлэлийн ажил нь техникийн шийдэл нь тохиромжтой, батлагдсан төсөвт өртөг нь хүрэлцэхгүйн улмаас хэрэгжээгүй;

ЗТС-ын багцад

- ✦ Говь-Алтай аймгийн нисэх онгоцны буудлын онгоц, өөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан байгуулах 7,385.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй ажлыг “Заабар” ХХК 2008 оноос хойш гүйцэтгэж байгаа боловч хугацаандаа ашиглалтанд ороогүй;
- ✦ Завхан аймгийн нисэх онгоцны буудлын онгоц, өөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан байгуулах 8,651.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй ажлыг “Хурдны зам” ХХК 2008 оноос хойш гүйцэтгэж байгаа боловч хугацаандаа ашиглалтанд ороогүй;

БХБС-ын багцад

- ✦ 75,386.8 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээ гэрээгээ сунгаж 1-3 жил үргэлжилж байна.

3.14 Төсвийн тухай хуулийн 29.3.5¹⁴-д заасан заалтыг өрчин төсвийн хөрөнгөөр санхүүжигдэж байгаа зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн санхүүжих дүн нь төсөвт өртгийн 20-30 хувь, үүнээс ч бага хувиар батлагддаг нь томоохон барилга байгууламжийг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэх боломжгүй болгож байна.

Гүйцэтгэгчид хэд хэдэн ажил давхар гүйцэтгэж байгаа нь хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

3.15 Тендерт оролцогч аж ахуйн нэгжүүд санхүүгийн болон ажиллах хүчний нөөц, техник тоног өхөөрөмжийн хүчин чадлаа бүрэн тооцоо лгүйгээр худалдан авах ажиллагаанд оролцож, олон ажил авсанаас хэрэгжилт удаашрах нөхцлийг бүрдүүлж байна. Тухайлбал,

ИНЕГ-м

- ✦ Сүхбаатар, Хэнтий аймгуудын нисэх буудлыг өөрч буух, шороон зурвасын ажлын гүйцэтгэгчээр “Талын зам” ХХК-ийг шалгаруулсан боловч Хэнтий аймгийн нисэх буудлын ажил 20 хувийн гүйцэтгэлтэй, хөрөнгийн эх үүсвэргүйгээс ажил зогссон;
- ✦ Бүсийн нислэг хөдөлгөөний удирдлагын төвийн барилга, мөн энэ барилгын дэд өртөө, гадна цахилгаан, холбооны ажил (УБ. Хан-Уул дүүрэг)-ын гүйцэтгэгчээр шалгарсан “Үүрэг трейд” ХХК хугацаандаа хэрэгжүүлээгүй учраас гэрээ сунгагдсан;
- ✦ Мөн “АЧ СВС” ХХК 2011-2013 онд жил бүр 3-4 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр шалгарсан боловч ашиглалтад орох хугацааг сунгасан;

БШУС-ын багцад

- ✦ Архангай аймгийн Хангай, Жаргалант сумын 75 хүүхдийн дотуур байрны барилгын ажлын тендерт “Ди Си Эйч” ХХК шалгарч ажлаа эхэлж тус бүр 550.0 сая төгрөгийн санхүүжилт авсан, ажлын гүйцэтгэл дундажаар 30 -50 хувьтай, одоогоор барилгын ажил зогссон байна.

3.16 Хандивлагч орнуудын зээл, буцалтгүй тусла мжаар хэрэгжүүлж буй томоохон замуудын гүйцэтгэгчээр шалгарсан БНСУ-ын компаниуд тухайн ажлыг 3 жил болон түүнээс дээш хугацаагаар удаашируулдаг дутагдал 2007 оноос хойш давтагдсаар байна. Тухайлбал,

- ✦ 2006 онд эхэлсэн “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төслийн хүрээнд хэрэгжүүлэх “Чойр - Сайншанд-Замын-Үүд” чиглэлийн замын гүйцэтгэгчээр “Эл Ай Жи”, “Ханшин инженеринг”

¹⁴ Төсвийн тухай хуулийн 29.3.5-д “Шинээр эхлэх барилга байгууламжийн төсөвт өртөгөөс тухайн жилд ногдох хэсэг нь хэрэгжих хугацаанд тэнцүү хувиарласан хэсгээс багагүй байхаар тооцож тусгана”

компаниуд шалгарснаар гэрээг олон дахин сунгажүргээ удаа дараа зөрчсөний эцэст ажлаа дуусгахгүйгээр гэрээг цуцалж байсан;

- ✦ Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтын сангийн зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Уньт-Тариалан” чиглэлийн 88 км замын нэгдэл багцад БНСУ-ын “Век Сок констрашн” шалгарч 2012 онд гэрээ байгуулсан боловч 2014 оны 4 дүгээр сарын 01 -ний байдлаар 28 хувийн гүйцэтгэлтэй гарч, ЗТЯ-ны ТНБД-ын 2014 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 96 тоот тушаалаар дээрх ажлын гэрээг цуцлах шийдвэр гаргасан;
- ✦ Германы сэргээн босголтын банкны зээлээр хэрвэж “ Нийслэл хотын үмсний найдвартай байдлыг хангах орон нутгийн тээврийн дэдтцийг хөгжүүлэх ” төслийн хүрээнд хэрэгжих 78.8 км хатуу хучилттай замын 2 дугаар багцын гүйцэтгэгчийг шалгаруулах ажил 3 жилүргэлжилж, 2013 оны 12 дугаар сард гэрээ байгуулсан боловч ажлын гүйцэтгэл “0” хувьтай байна.

Хяналтын үр нөлөөтэй тогтолцоо дутагдаж байна

3.17 Захиалагчийн зүгээс гүйцэтгэгчид тавих хяналт сул, барилга угсралтын үе шатны хяналтыг бүрэн хийхгүй, хариуцлага тооцохгүйгээс гүйцэтгэгч компаниуд, Төсвийн тухай хууль¹⁵, Иргэний хуулийн 350.1.1¹⁶ дэх заалтыг өрчиж , гэрээнд заасан хугацаанд барилга, объектыг ашиглалтад өгөхгүй, ажлын чанар, үр дүн ч хангалтгүй байна.Тухайлбал,

БШУС-ын багцад

- ✦ Дорноговь аймагт баригдаж байгаа Анагаах ухааны коллежийн өргөтгөл, спорт заалны барилгын гүйцэтгэгч “Элком” ХХК;
- ✦ Завхан аймгийн Сонгино суманд баригдаж байгаа 100 ортой цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгч “Арь констрашн” ХХК;
- ✦ Өвөрхангай аймгийн Есөнзүйл суманд баригдаж байгаа бага сургуулийн болон дотуур байрны барилгын гүйцэтгэгч “ТЭТҮ” ХХК
- ✦ Өмнөговь аймгийн Цогт-Овоо суманд баригдаж байгаа 80 ортой сургуулийн дотуур байрны барилгын гүйцэтгэгч “Хөвсгөл аяны жолоо” ХХК
- ✦ Хэнтий аймгийн Норовлин суманд баригдаж байгаа 320 суудалтай сургуулийн барилгын гүйцэтгэгч “ӨВМТХ” ХХК-иуд ажлаа хугацаандаа дуусгаагүй;
- ✦ Архангай аймгийн Ихтамир сумын 75 ортой дотуур байрны барилга угсралтын ажлын төсөвт өртөг нэмэгдэж батлагдсаны дагуу нэмэлт гэрээг 2013 оны 8 дугаар сарын 08-наас 8 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд “Тамирын цахиур” ХХК-тай байгуулж, гүйцэтгэлийг 35 хоногоор хоцроосон байхад хугацаандаа гүйцэтгэсэн гэж дүгнэсэн;
- ✦ Архангай аймгийн Хангай сумын 400үждийн хичээлийн байрны их засварын ажлыг “Цогт-Өнжүүл”ХХК гүйцэтгэж 2013 оны 9 дүгээр сарын 13-нд комиссын актаар үлээн авч, хугацаатай үүрэг даалгавар өгсөнч өнөөдрийг хүртэл зөрчлийг арилгаагүй, дахин засвар хийх хэмжээнд хүрсэн;

ШС-ын багцад

- ✦ Төв аймгийн Зуунмод хотод баригдаж буй МХЕГ-ын лабораторийн барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийх гэрээ байгуулаагүй;

ЭЗХС-ын багцад

- ✦ МҮОНРТ-ийн цахилгааны дэд станцын шинэчлэлийн ажилд зохиогчийн хяналт хийх гэрээг 2013 оны 6 дугаар сарын 25-ны өдөр байгуулж, хяналтыг 2 удаа хийсэн гэх боловч эхний хяналт баримтаар нотлогдохгүй, 2 дах хяналтыг 2013 оны 11 дүгээр сарын18 -нд хийсэн бөгөөд 4 сарын дараа өмнө өгсөн алдаа зөрчлийг арилгаагүй гэсэн дүгнэлт гаргасан;

ХС-ын багцад:

- ✦ Баянхонгор аймгийн МӨТ -ийн “Бөсөгчдийг ажлын байраар хангах, бичил нийтийн ахуйн үйлчилгээний төв” барих төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг Баянхонгор аймгийн ЗДТГ-аас 2013 оны 1 дүгээр сарын 29 -нөөс мөн оны 3 дугаар сарын 1 хүртэл зохион байгуулж харьцуулалтын аргаар “MBS-AS” ХХК

¹⁵ Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт” Монгол Улсын төсвийн хөрөнгөөронд хэрэгжүүлэх хөрөнгөн оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”

¹⁶ Иргэний хуулийн 350.1.1-д “Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ”

шалгарсан боловч тус компани нь барилгын ажил эхлэж өвшөөрөлгүй, мөн зохиогчийн хяналтын гэрээ хийлгэжээ барилга угсралтын ажлыг явуулсан;

БХБС-ын багцад:

- ✦ Бохир усны шугамын шинэчлэл, цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэл (Хөвсгөл.Мөрөн) 937.8 сая ;
- ✦ Хотын төвийн болон үйлдвэрийн районы цэвэр, бохир усны шугам, тоног төхөөрөмж, цэвэрлэх байгууламжийн шинэчлэлтийн зураг өгөөл боловсруулах (Завхан.Улиастай) 80.0 сая;
- ✦ Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотгол хийх (улсын хэмжээнд) 163.0 сая төгрөгийн ажлууд гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас шалтгаалан хэрэгжих боломжгүй болсон байна.

3.18 Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгай нөхцөл, хоёр талын эрхүүргийг хэт ерөнхий тусгаснаас гэрээг үфэн дүгнэж хэвшээгүй, үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй хариуцлага тооцож чадахгүйд хүрч байна.

3.19 Захиалагчийн зүгээс гүйцэтгэгчид тавих хяналт сул, гүйцэтгэгч байгууллагууд үүргээ биелүүлэхгүй байгаа нь барилгын ажлын чанарт сөргөөр нөлөөлж байна.Тухайлбал,

- ✦ Архангай аймгийн Тариат сумын 20 ортой эмнэлгийн барилгын гүйцэтгэгчээр шалгарсан “Хатиган болор” ХХК нь ажлыг зураг өгт свийн дагуу хийгээгүй (дотор ханыг тоосгоор барихыг блокоор орлуулсан), өм хасах температурт цутгаа лт хийж, дээж авч шинжлүүлээгүй, дотор халаалтын системийг цахилгаан халаагуураар сольсон зөрчлийг засуулаагүй, хариуцлага тооцоогүй;
- ✦ Архангай аймгийн Ихтамир сумын Эрүүл мэндийн төвд их засвар хийсэн боловч цэвэр усны насос ус муу шахдаг, пелта хагарсан, парктен шал овойсон зэргээс шалтгаалж, ашиглалт хангалтгүй, гүйцэтгэгч “Цагаан сүмбэр”ХХК-иар засуулахаар албан бичиг хүргүүлсэн;
- ✦ Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын 15 ортой эмнэлгийн барилгын засварыг “ӨВМТХ” ХХК нь чанаргүй гүйцэтгэснээс цонх цантаж өлөрдөг, ус гоож дог, гадна хаалга чанар муутай, доогуураа хөндий зай ихтэй, цас, шороо ордог, паарнаас ус гоождог, жийргэвчнүүд нь сэтэрдэг, шулуун паарнууд нь цоорхой, душанд орох боломжгүй, ус нь гадагш хальдаг, ханын будаг амархан халцардаг, угаалтуурын хоолойноос ус гоождог, гал тогооны 2 дамжлагат угаалтуур хөдөлгөөнтэй;
- ✦ Өвөрхангай аймгийн Уянга сумын эмнэлгийн барилгын засварын ажлыг “ДШЛ” ХХК гүйцэтгэж 2013 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр улсын комиссын актаар өгсөн 14 төрлийн үүрэг даалгаварыг огт биелүүлээгүйгээс дээврээс дусаал гоождог, угаалгаврөөний таазны шавар бүхэлдээ нурсан, уур сорогч ажиллахгүй, зарим өрөөний хаалганууд хагарсан байдалтай байна.

3.20 Барилга угсралтын ажил эхлэх нөхцлийг бүрэн хангаагүйгээс барилгын ажил удаашрах, улмаар хугацаандаа ашиглалтад орохгүй байхад ч хүргэж байна.Үүнд,

- ✦ Цус сэлбэлт, судлалүндэсний төвийн барилгын гүйцэтгэгчээр “Грийн ресурс констракшн” ХХК шалгарч Барилга угсралтын гэрээг 2,949.4 сая өгрөгөөр барьж гүйцэтгэхээр 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдөр гэрээ байгуулсан боловч барилгын талбайд механизм оруулах гарц байхгүй, ц ахилгаан ашиглах эвшөөрөл аваагүйгээс 2013 оны 8 дугаар сарын 8-ны өдрөөс суурийн давхрын ажил эхэлж, 2013 оны байдлаар дөнгөж суурийн давхрын ажил хийгдсэн байна.

3.21 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2013 онд хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнээс өрөнгүй арга хэмжээ хуул ь, хяналтын байгууллагад шалгагдаж байна.Тухайлбал,

БХС-ын багцаас:

- ✦ “Тэмүүжин-Өрлөг” төслийн Ерөнхий боловсролын сургуулийн цогцолбор төвийн барилга

(УБ.БЗД),

- ✚ Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын өргөтгөлийн барилга (УБ.БЗД);
- ✚ Цэргийн албан хаагчдын албан тушаалын 63 айлын орон сууц (УБ.БЗД);
- ✚ Цэргийн албан хаагчдын албан тушаалын 16 айлын орон сууц (Хэнтий, Дэлгэрхаан);
- ✚ "Цэрэг спортын төв цогцолбор" төсөл (УБ.БЗД- Алдар спорт хороо);

ЕС-ын багцаас:

- ✚ "Аймгуудад нэгдсэн оношлогооны гөв бий болгох" төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны гүйцэтгэгч шалгаруулалтад 2 удаа гомдол гарсан учраас шалгагдаж байгаа;
- ✚ Аймгийн төвүүдэд битүү зах, худалдааны төв барих" төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгаруулах ажиллагаанд гомдол гарсан тул тус тус шалгагдаж байна.

2013 онд батлагдсан хөрөнгийн 70.1 хувийг санхүүжүүлжээ

3.22 2013 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,661.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 1,124.3 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээс 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 787.8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, 336.5 тэрбум төгрөгийн эрх нээгдээгүй үлджээ.

2013 онд улсын төсвөөс батлагдсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийг төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр харуулбал,

(сая төгрөгөөр)

д/д	Үзүүлэлт	Төсөвт өртөг	Тоо	2013 оны төсөв	Тоо	Нийт санхүүжилт	Үлдэгдэл	Хувь
1	ЕТГ	516.9	3	362.0	3	157.7	204.3	43.6
2	УИХ	453.2	2	453.2	2	370.5	82.7	81.8
3	ЕС	185,485.9	37	91,386.1	31	57,519.3	33,866.8	62.9
4	ЗГХЭГ	18,949.9	27	11,837.9	23	8,358.7	3,479.2	70.6
5	ГХС	15,974.5	8	11,541.5	8	10,055.0	1,486.5	87.1
6	СС	22,182.0	26	11,648.2	23	6,571.5	5,076.7	56.4
7	БХС	53,419.2	14	17,739.1	14	13,907.2	3,831.9	78.4
8	ЭМС	105,505.0	122	40,815.5	109	22,161.8	18,653.7	54.3
9	ҮХЦ	170.4	4	170.4	4	166.9	3.5	97.9
10	УДШ	792.0	5	792.0	4	497.2	294.8	62.8
11	ШЕЗ	7,619.3	5	7,619.3	5	7,033.9	585.4	92.3
12	УЕП	13,180.8	14	10,121.2	13	8,466.4	1,654.8	83.7
13	ҮАБЗ	497.9	2	497.9	2	491.8	6.1	98.8
14	ЕА	69.5	1	69.5	1	69.5	0.0	100
15	ҮСХ	231.0	2	231.0	2	183.9	47.1	79.6
16	ТАЗ	64.7	3	64.7	3	64.8	0.0	100
17	ЦАУЗБК	16.3	1	16.3	1	16.0	0.3	98.2
18	ШС	46,545.3	47	22,899.7	46	20,217.9	2,681.8	88.3
19	АТГ	3,001.4	5	3001.4	5	2,984.8	16.6	99.4
20	БОНХС	10,339.1	27	4,469.3	26	4,063.1	406.2	90.9
21	ХЗС	106,139.5	22	44,960.3	21	29,952.3	15,008.0	66.6
22	БХБС	372,567.3	88	99,947.2	71	69,611.3	30,335.9	69.7
23	БШУС	285,823.8	161	116,520.7	140	78,910.0	37,610.7	67.7
24	ЗТС	777,436.0	109	332,753.9	97	260,706.6	72,047.3	78.4
25	ССАЖС	114,796.6	47	42,721.3	37	28,186.0	14,535.3	65.9
26	УУС	6,009.2	10	4,517.7	9	3,825.8	691.9	84.7
27	ҮХААС	125,469.0	34	54,846.0	33	35,350.1	19,495.9	64.5
28	ХС	21,950.0	26	13,446.8	23	8,349.3	5,097.5	62.1
29	ХАХНХС	16,547.6	17	9,504.0	17	8,722.5	781.5	91.8
30	ЭЗХС	60,655.6	9	52,070.1	7	8,692.8	43,377.3	16.7
31	ЭХС	289,571.0	91	117,127.4	82	92,025.5	25,101.9	78.6
32	ХЭҮК	20.0	1	20.0	1	19.9	0.1	99.4
33	СЕХ	133.8	2	133.8	3	129.0	4.8	96.4
	НИЙТ	2,662,133.8	972	1,124,305.4	865	787,838.8	336,456.5	70.1

*Эх сурвалж: Сангийн яамны Төрийн сангийн газар

3.23 2013 оны төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэл дутуу байсантай холбоотойгоор санхүүжилт бүрэн хийгдээгүй байна.

3.24 Гэрээний дагуу өлөвлөгөөт ажлаа гүйцэтгээгүй, х өрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг захиалагч, ашиглагч,үйцэтгэгч байгууллагын холбогдох ажилтнууд хуурамчаар бүрдүүлэн санхүүжилт олгосон тохиолдол гарсан байна.Тухайлбал,

- ✦ Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нэгдүгээр сургуулийн 145.8 сая төгрөгийн дээврийн засварын ажлыг гүйцэтгэгч “Цамц” ХХК 20 хувийн ажил хийсэн байхад 2013 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр техникийн комисс дээрх засварын ажлыг “9 дүгээр сараас 11 дүгээр сарын 5-нд дуусгасан” гэж хуурамч баримт үйлдэн санхүүжилтийг бүрэн олгосон;
- ✦ Өвөрхангай аймгийн Хужирт сумын ЕБС-ийн дотуур байрны засварыг “Смарт зоос” ХХК 49.5 сая төгрөгөөр хийж гүйцэтгэх хдээ ажлыг чанаргүй, дутуу хийсэн байхад 2013 оны 12 дугаар сард засварын ажлыг дуусгаснаар хуурамч баримт үйлдэн санхүүжилтийг бүрэн олгосон;
- ✦ Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын ЕБС-ийн спорт заалны их засварыг “Марзат цамхаг” ХХК 50.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр гэрээ хийж 80.0 хувийг гүйцэтгэсэн боловч гүйцэтгэлийн баримтыг хуурамчаар үйлдэн санхүүжилтийг бүрэн олгосон;
- ✦ Хөвсгөл аймгийн Ханх сумын 1,061.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 100 ортой хүүхдийн дотуур байрыг “Бумбах” ХХК 2012-2013 онд барьжүйцэтгэх гэрээ байгуулсан боловч ажлын гүйцэтгэл дутуу байхад аймгийн ГХБХБГ-ын хяналтын инженер ажлыг хийснээр баталгаажуулан төсөвт тусгагдсан 783.0 сая төгрөгийг гүйцэтгэгчид олгосон;
- ✦ Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын соёл спортын цогцолборын барилга 1,314.3 сая төгрөгийн санхүүжилтийн 95.4 хувийг олгосон боловч гүйцэтгэл нь хангалтгүй;
- ✦ Мөн аймгийн Галт сумын 100 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажилд 81.4 сая төгрөгийг хуурамч гүйцэтгэлээр олгосон;
- ✦ Төв аймгийн Алтанбулаг сумын Туулголын модон гүүрийн засварын ажлыг 2013 оны 12 дугаар сарын 25-наас 2014 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр гүйцэтгэж, ашиглалтад оруулах (улсын төсвөөс 100.0 сая, орон нутгийн хөгжлийн сангаас 30.1 сая)-аар гэрээ байгуулсан өдөр гүйцэтгэгч “Ойл Рөүд”ХХК 60.0 хувийн гүйцэтгэл гарган 75.8 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

3.25 Энэ нь өрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ ний гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүйг харуулж байна.

3.26 Засгийн гарын 2014 оны 1 дүгээр сарын 28 -ны өдрийн “Улсын төсвийн 2013 оны хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний төлбөрийг баталгаажуулах тухай” 26 дугаар тогтоолоор 2013 оны төсвийн тухай хуульд тусгагдаж, тухайн төсвийн жилд санхүүжигдээгүй, 276 төсөл, арга хэмжээний гэрээний үлдэгдэл төлбөр бүхий 155.4 тэрбум төгрөгийг векселиэр баталгаажуулсан байна.Тухайлбал,

- ✦ БШУС-ын багцад 21,830.7 сая;
- ✦ БХБС-ын багцад 23,346.9 сая;
- ✦ ЕС-ын багцад 8,063.2 сая;
- ✦ ЭХС-ын багцад 15,507.8 сая;
- ✦ ЗТС-ын багцад 42,007.7 сая;
- ✦ ЭЗХС-ын багцад 9,476.1 сая;
- ✦ ЭМС-ын багцад 5,640.5 сая төгрөг г.м баталсан байна.

3.27 ЕС-ын багцад хэрэгжүүлж байгаа шинэчлэлийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтад батлагдсан 50.0 тэрбум төгрөг ийн хөрөнгө оруулалтаас 2 6,089.1 сая

төгрөгийг санхүүжүүлсэний 63.3 хувь буюу 16,531.4 сая төгрөгийг 2013 оны 12 дугаар сард шилжүүлсэн байна.

3.28 СС-ын 2012 оны 290 үдээр тушаалын 5 дугаар зүйлийн 5.1¹⁷ дэх заалтыг зөрчин улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ, барилга байгууламжийг бүртгэл, тайланд бүрэн тусгаагүй, зарим нь алдаатай бүртгэгдсэн байна. Тухайлбал,

- ✦ БШУС-ын багцаас зарцуулсан Архангай аймагт 1,318.1 сая, Дундговь аймагт 2,141.1 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг бүртгэл тайланд тусгаагүй
- ✦ МҮОНРТ-д дүрс дууны архивын тоног төхөөрөмж нийлүүлэх тендерт шалгарсан “Глобал телеком” ХХК нь 2013 оны 11 үдээр сарын 13 -нд 33 нэр төрлийн 974.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг актаар хүлээлгэн өгсөн боловч бүртгэлд тусгахдаа улсын төсвөөс олгосон хөрөнгийн дүнгээр буюу 400.0 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авснаар 9 нэр төрлийн 380.0 сая төгрөгийн хөрөнгийн нэг бүрийн үнийг өсгөн 19.9 сая төгрөгөөр нэмж бүртгэсэн;
- ✦ Радиогийн архивыг тоон технологид шилжүүлэх 878.9 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээний хэрэгжилтээр 868.2 сая төгрөгийг үндсэн хөрөнгөөр, 10.7 сая төгрөгийг сэлбээ хэрэгслээр бүртгэсэн;
- ✦ Говь-Алтай аймгийн 304.0 сая төгрөгөөр инженерийн хийцтэй 20 худгийг шинээр гаргаж орон нутгийн байгууллагад хүлээлгэн өгснөөс Баян-Уул сумын 3 худгаас бусад худаа гаргуулсан сумдын ЗДТГ нь 258.4 найу өгөөдөөдөө худгийг агуулах үйлдлийг тусгаагүй;
- ✦ Увс аймагт 181.1 сая төгрөгөөр 13 цэгт худгийг орон нутагт хүлээлгэн өгсөн ч бүртгэл тайланд тусгаагүй;
- ✦ Дархан-Уул аймгийн Орхон суманд “Ус хангамж, ариутгах татуургын системийн шинэчлэлийн ажил” 2,487.8 сая;
- ✦ Увс аймагт “Цэвэр усны цагираг шугам” 741.6 сая;
- ✦ Дундговь аймгийн Сайнцагаан сумын “Газар хөдлөлтийг бүртгэх станцын барилга” 180.0 сая, 6 дугаар цэцэрлэгийн барилгын их засвар 48.0 сая, “сургуулийн барилга, 960 суудал” 1,900.1 сая, нийт 2,128.1 сая;
- ✦ Мөн аймгийн Дэлгэрхангай сумын “Анхны сургуулийн их засвар” 13.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг тус тус бүртгэлд тусгаагүй байна.

3.29 Зураг төсвийг үндэслэл, тооцоо муутай хийснээс зарим хөрөнгө оруулалт үр ашиг муутай байна. Тухайлбал,

- ✦ Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ суманд баригдаж байгаа 1,314.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй соёл, спортын цогцолборын гүйцэтгэгч “Тэмээн” ХХК нь 2012 оны 8 дугаар сарын 8-ны өдрөөс 2013 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэл барьж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч хугацаандаа ашиглалтад өгөөгүй, гүйцэтгэл хангалтгүй, уг цогцолборын хүлээлгийн танхим барилгын нийт талбайн 1/3-ийг эзлэж байгаа нь ашиггүй зардал гаргахад нөлөөлж байна.
- ✦ УБ хот Чингэлтэй дүүрэг эг “Дэнжийн 1000-ын цахилгааны шугамыг чөлөөлөх, шилжүүлэх ажил”-ыг 2013 оны 11 дүгээр сарын 27-ны (494.8 сая төгрөг) өдөр ашиглалтад хүлээж авсан боловч ашиглалтгүй байна.

3.30 ЭМЯ нь тоног төхөөрөмж ийн нэгдсэн бодлого зохицуулалт, судалгаа, бүртгэлгүйгээс аль эмнэлэгт ямар тоног төхөөрөмж шаардлагатай эсэх нь тодорхойгүй, ашиглалтын хяналт сулаас зарим эмнэлэгт нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж ашиглалтгүй хадгалагдаж байна. Тухайлбал,

¹⁷ Сангийн Сайдын 2012 оны 290 дүгээр тушаалын 5 дугаар зүйлийн 5.1¹⁷ дэх “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн, эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламж, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтанд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр тухайн төсөвт байгууллагын тайлан балансанд бүртгэнэ”

- ✦ 3 дугаар амаржих газарт 2013 онд нийлүүлсэн 72.2 сая төгрөгийн өртөг тэй тэргэнцэр, автоклав зэрэг тоног төхөөрөмжүүд;
- ✦ “Энэрэл” эмнэлэгт 2013 онд нийлүүлсэн 120.1 сая төгрөгийн өртөг тэй ходоодны дуран, тархины цахилгаан бичлэгийн аппарат, эмэгтэйчүүдийн ор зэрэг тоног төхөөрөмжүүд нь байрны хүрэлцээгүйгээс агуулахад хадгалагдаж байгаа;
- ✦ Архангай аймгийн нэгдсэн эмнэлэгт 2013 онд нийлүүлэгдсэн 197.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөс 2.8 сая төгрөгийн өртөг бүхий хүчилтөрөгч өтгөрүүлэгч, дуслын автомат шахуурга нь гэмтэлтэйгээс ашиглаагүй;
- ✦ Нийслэлийн клиникийн нэгдүгээр амаржих газарт 2013 оны 5 дугаар сард “Лабтек” ХХК-иас нийлүүлсэн 245.0 сая төгрөгийн өртөгтэй 4 D ЭХО аппарат нь ажиллагаагүй, зөөврийн рентген аппарат бүрдэл дутуу нийлүүлэгдсэн, мэс заслын дурангийн багаж ашиглагдах боломжгүй, хэвлийн дурангийн аппарат эвдрэлтэй, “Доктор Айболит” ХХК-ийн нийлүүлсэн 78.8 сая төгрөгийн өртөгтэй ургийн монитор, умайн хүзүү шалгах багаж, нярайн отсос, зөөврийн инкубатор зэрэг тоног төхөөрөмжүүд нь ашиглалтын шаардлага хангахгүй;
- ✦ Увс аймгийн нэгдсэн эмнэлэгт “Оношилгоонөв”-ийн тийшээр байгуулахад 2 ,151.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж ирснээс “Чоно гол” ХХК, “Си ай ти” ХХК, “Сетунари” ХХК-ийн нийлүүлсэн тоног төхөөрөмжүүд иж бүрдэл дутуу, техникийн шаардлага хангахгүй байна.

3.31 Улсын төсвөөс 2013 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар ҮАГ -аас 1,295.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, аймаг, нийслэлийн аудитын газар 49.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоо н, 9,124.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн байна.

3.32 2013 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл ДНБ-ний 4.5 хувийг эзэлж байна.

3.33 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн ТЭЗҮ, зураг, төсөв бэлэн болоогүй, худалдан авах ажиллагааг зохион байгуулахад цаг хугацаа алддаг, барилга угсралтын ажлын үе шат бүрт тавих хяналт сул байгаагаас хугацаа сунжирч, хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. 2013 онд улсын өмчийн хөрөнгө оруулалтаар 6248 суудалтай 12 сургууль, 2150 ортой 24 цэцэрлэг, 1430 ортой 7 дотуур байр, 11 спорт заал, 270 ор бүхий 12 эмнэлэг, 415 инженерийн хийцтэй худаг, 336.3 км хатуу хучилттай зам ашиглалтад оруулсан байна.
2. 2013 оны төсвийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 972 төсөл, арга хэмжээ, үүний дотор 625 барилга, байгууламж батлагдсанаас ашиглалтад орсон 283, шилжих 157, дутуу хэрэгжсэн 171, хэрэгжээгүй 14 арга хэмжээ байна.
3. 2013 оны өрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх ажлын зохион байгуулалт, гүйцэтгэлийг авч үзвэл дараах нийтлэг зөрчил, дутагдал гарч байна. Үүнд,
 - Хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр боловсруулаагүй, нийгмийн ач холбогдол, хэрэгцээ шаардлагад тулгуурлан эрэмбэлсэн нэгдсэн төлөвлөгөөгүй байгаа нь төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.
 - Хөрөнгө оруулалтыг төлөвлөх, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, хянаж баталгаажуулах, техникийн үржүүлэх хангах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах, үнэмлэх, хяналт тавих зэрэг хөрөнгө оруулалтын бүх үе шатанд нэгдсэн бодлого зохицуулалт дутагдаж байна.
 - Хуульд заасан шаардлагыг хангаагүй объектыг төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгаснаас өс зураг т вийг боловсруулах, баталгаажуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зэрэг үйл ажиллагаанд ихээхэн хугацаа зарцуулж байгаа нь төсөл, арга хэмжээ ний хэрэгжилтийг удаашруулж байна.
 - Хөрөнгө оруулалтын болон барилга угсралтын ажлын үе шат бүрт тавих мэргэжлийн байгууллагуудын болон захиалагчийн хяналт хайгуур төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн чанарт муу нөлөө үзүүлж байна.
 - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн худалдан авах ажиллагааны болон бусад баримт бичиг дутуу, иж бүрдэлгүй, эмх цэгцгүй, архивын нэгжийн бүрдүүлэлт хийгдээгүй дутагдал нийтлэг байна.


Холбогдох байгууллагын санал

--	--

**ҮАГ-ын
тайлбар**

Тайлбар 1-ийг үзнэ үү.

Тайлбар 2-ыг үзнэ үү.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР А.ЗАНГАД ТАНАА

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-02-47, http://www.mof.gov.mn


2014-06-06 № 4-У/3101
танай _____-ны № 803 -т


Санал өгөх тухай

Улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна.

- Төсвийн ерөнхийлөн захирагч нарт дараах зөвлөмжийг өгөх. Үүнд:
 - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа барилга байгууламж, төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэлийг батлагдсан зураг төсвийн дагуу хянаж, хэмжин шалгалт хийсний үндсэн дээр гаргах, захиалагчийн техникийн хяналтыг тогтмол тавьж барилга байгууламжийг цаг хугацаанд нь ашиглалтад оруулах талаар онцгой анхаарч ажиллах,
 - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилга байгууламж, худалдан авсан техник, тоног төхөөрөмжийг төрийн болон орон нутгийн өмчид заавал бүртгэж байх.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа барилга байгууламж, төсөл, арга хэмжээний тендерийг эхний улиралд багтаан шуурхай зохион байгуулж байх талаарх зөвлөмжийг Худалдан авах ажиллагааны газарт өгөх мөн зураг төсөл, техникийн даалгаврыг Худалдан авах ажиллагааны газарт шуурхай хүргүүлж байх талаарх зөвлөмжийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус өгөх нь зүйтэй гэсэн саналтай байна.

Хүндэтгэсэн,

САЙД  Ч.УЛААН



п 2140

<p>Тайлбар 3-ыг үзнэ үү.</p>	<p>УНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР</p> <p>МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ</p> <p>15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэсллийг гудамж 5/1, Засгийн газрын II байр, Утас/Факс: (976-51) 25-33-33, E-mail: info@med.gov.mn, http://www.med.gov.mn</p> <p>2014.06.09 № 3/1195 танай _____ -ны № _____ -г</p> <p>Санал өгөх тухай</p> <p>"Улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Аудит хийх явцад санхүүгийн ихээхэн баримт материалд хяналт, шинжилгээ хийсэн боловч зөрчлийн шалтгаан нөлөөлсөн хүчин зүйлийг тодорхой тооцоо баримтаар нотлох явдал дутагдалтай байна. 2. Хөрөнгө оруулалтын төсөл, барилга байгууламжийн гүйцэтгэл, үр дүнд аудит хийхдээ бодит хэмжилт, инженерийн тооцооллын хяналт дүгнэлтийг орхигдуулж байна. 3. Төсвийн ерөнхийлөн захирагчдын багц дахь хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилт хангалтгүй, хууль зөрчсөн олон үйлдлийн талаар дурьдсан мөртлөө Аудитын зөвлөмжид ерөнхий, бүрхэгдүүлсэн заалт тусгасныг тодорхой болгон холбогдох сайд нарт зөвлөмж хүргүүлэх, 4. УИХ-аар төсвийн тухай хууль хэлэлцэх явцад эсвэл Засгийн газрын өргөн барьсан хуулийн төслийн аль үед нь зураг төсөөгүй, хуулийн шаардлага хангаагүй төсөл тусгагдаж байгааг тодруулж, зөвлөмжид тусган, УИХ-ын дарга, Ерөнхий сайдад холбогдох зөвлөмж хүргүүлэх, 5. Өөрийн буруугаас гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэчийг хуулийн дагуу нягтлан шалгаж, хар жагсаалтад бүртгэж байх талаар Сангийн сайдад зөвлөмж болгох, 6. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламж, бүтээн байгуулалтын аливаа ажлын зураг, төсөл боловсруулах ажлын чанар, төсөвт өртгийг үнэн зөв тодорхойлсон байдал нь техник, технологийн шийдэл гаргах, суурь норм, норматив, стандарт боловсруулах аргачлал, судалгаа шинжилгээний чадавхи, хариуцлагаас шалтгаалж байгааг харгалзан холбогдох сайд нарт энэ талаар авах арга хэмжээний зөвлөмж хүргүүлэх зэрэг болно. <p>ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА <i>B. Shinsabaatar</i> Б.ШИНЭБААТАР</p> <p>8 2006</p>
<p>Тайлбар 4-ийг үзнэ үү.</p>	
<p>Тайлбар 5-ыг үзнэ үү.</p>	
<p>Тайлбар 6-г үзнэ үү.</p>	
<p>Тайлбар 7-г үзнэ үү.</p>	
<p>Тайлбар 8-ыг үзнэ үү.</p>	

Тайлбар

Сангийн яамнаас ирүүлсэн санал

Тайлбар 1	Саналыг хүлээн авлаа.
Тайлбар 2	Саналыг хүлээн авлаа.

Эдийн засгийн хөгжлийн яамнаас ирүүлсэн санал

Тайлбар 3	Саналыг хүлээж авлаа
Тайлбар 4	Саналыг хүлээж авлаа
Тайлбар 5	Саналыг хүлээн авч зөвлөмжид тусгав
Тайлбар 6	Саналыг хүлээн авч зөвлөмжид тусгав
Тайлбар 7	Өмнөх аудитаар өгсөн дүгнэлтээр хар жагсаалт гаргасан болно
Тайлбар 8	Саналыг хүлээн авч зөвлөмжид тусгав

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягт:

1. Улсын Их Хурлын 2012 оны Монгол Улсын 2013~~өсвийн~~ тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 ~~өсвийн~~ тухай, Хүний хөгжил сангийн 2013 оны ~~өсвийн~~ тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 60 дугаар тогтоолын 1.3, 1.5 дах заалтын хэрэгжилтийг хангах;
2. Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дор дурдсан асуудлуудыг авч үзэж, шийдвэрлэх;
 - 2.1 Засгийн газрын 2010 оны “Барилгын нэгж талбай~~өвт~~ өртөг, төсвийн жишиг үнэлгээ батлах тухай” 336 дугаар тогтоолоор баталсан жишиг үнэлгээг хянан үзэж, шинэчлэн тогтоох, түүнийг хөрөнгө оруулалтын өлөвлөлт, барилга байгууламжийн зураг, төсөв боловсруулахад баримтлах журмыг баталж, мөрдүүлэх;
 - 2.2 Хөрөнгө оруулалтын төлөвлөлтөөс эхлээд ашиглалтад хүлээж авах хүртэлх бүх үе шатанд мөрдөх нэгдсэн бодлого, зохицуулалтын стандарт, журмыг боловсруулах;
 - 2.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, геодезийн дүгнэлт гаргах, ажил гүйцэтгэх, санхүүжүүлэх үе шатанд захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулах гэрээний нэгдсэн стандарт бий болгож,үүнд урамшуулал, үнэлгээ, хариуцлага тооцох нөхцлүүдийг тодорхой тусгах;
 - 2.4 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад зарцуулах хугацааг богиносгох чиглэлээр зохих хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, объектыг барьж байгуулах хугацааг оновчтой төлөвлөх асуудлыг судалж шийдвэрлэх.

№	ТЭЗ	Төсөвт өргөж өлгөөл	2013 оны төсвийн тухай хууль	Хөрөнгө оруулалтын ангилал (санхүүжилт)					Тоо	Төсөвт өргөж өлгөөл	2013 оны төсвийн тухай хууль	Хөрөнгө оруулалтын ангилал (санхүүжилт)					Тоо	Төсөвт өргөж өлгөөл	2013 оны төсвийн тухай хууль														
				ХО		ТТ	ИЗ	ТЗЗҮ, зураг төсөл				ХО		ТТ	ИЗ	ТЗЗҮ, зураг төсөл																	
				2,013	төо							2,013	төо							2,013	төо												
1	ЕТГ	516.9	516.9	3	516.9	3	516.9		516.9	362.0	3	362.0		3	362.0		516.9	362.0	3	362.0		2,013		2,013		2,013		2,013		2,013			
2	УИХ	453.2	453.2	2	453.2	2	453.2		453.2	453.2	2	453.2		2	453.2		453.2	453.2	2	453.2		2,013		2,013		2,013		2,013		2,013			
3	БА	69.5	69.5	1	69.5	1	69.5		69.5	69.5	1	69.5		1	69.5		69.5	69.5	1	69.5		2,013		2,013		2,013		2,013		2,013			
4	ҮСХ	231.0	231.0	2	231.0	2	231.0		231.0	231.0	2	231.0		2	231.0		231.0	231.0	2	231.0		2,013		2,013		2,013		2,013		2,013			
5	ҮАБЗ	497.9	497.9	2	497.9	2	497.9		497.9	497.9	2	497.9		2	497.9		497.9	497.9	2	497.9		2,013		2,013		2,013		2,013		2,013			
6	ҮХЦ	170.4	170.4	4	170.4	4	170.4		170.4	170.4	4	170.4		4	170.4		170.4	170.4	4	170.4		2,013		2,013		2,013		2,013		2,013			
7	ТАЗ	64.7	64.7	3	64.7	3	64.7		64.7	64.7	3	64.7		3	64.7		64.7	64.7	3	64.7		2,013		2,013		2,013		2,013		2,013			
8	СЗХ	204.2	204.2	1	204.2	1	204.2		204.2		0			1	204.2					0			2,013		2,013		2,013		2,013		2,013		
9	ЦАУЗБУК	16.3	16.3	1	16.3	1	16.3		16.3	16.3	1	16.3		1	16.3		16.3	16.3	1	16.3		2,013		2,013		2,013		2,013		2,013			
10	ЕС	182034.4	88041.1	32	19	82660.0	7	3945.0	2	720.9	4	715.2	185485.9	91386.1	37	26	86160.0	7	3838.5	2	720.9	2	720.9		2	720.9		2	720.9		866.7		
11	ШС	50315.3	25423.4	52	14	10417.5	16	1952.8	21	2939.1	1	120.0	48545.3	22899.7	47	11	8767.5	15	11423.1	20	2589.1	1	120.0		1	120.0		1	120.0		120.0		
12	ГХЗ	19049.9	1937.9	30	11	8013.0	8	1636.1	10	1988.8	1	300.0	18949.9	1837.9	27	10	7953.0	7	1598.1	10	2288.8												
13	ГХС	15224.5	1187.5	8	3	4903.0	3	3870.0	2	2414.5			15974.5	1541.5	8	3	5653.0	3	3474.0	2	2414.5												
14	СС	37614.3	21637.0	32	11	15282.6	13	5060.0	8	1294.4			22182.0	1648.2	26	8	6637.8	11	3796.0	7	1214.4												
15	ХЗС	85702.6	36460.3	19	13	32638.6	3	3084.2	3	737.5			106139.6	44960.3	22	15	40138.0	4	4084.2	3	737.5												
16	ХЗС	302201.3	127397.4	97	85	19847.4							289571.0	117127.4	91	80	109577.4																
17	ҮҮС	7509.2	6017.7	12	5	2502.7	4	1252.0	1	238.7	2	2024.3	6009.2	4517.7	10	3	1002.7	4	1252.0	1	238.7	2	2024.3										
18	ЗТС	837268.6	421415.3	124	113	398779.3	6	1824.0	3	1092.0	2	3420.0	777436.0	332753.9	109	98	314467.9	6	13774.0	3	1092.0	2	3420.0										
19	БХС	447627.3	186327.1	118	89	175380.9	13	7187.2	3	704.0	13	3055.0	372567.2	99947.2	88	61	91133.9	13	5987.8	2	151.5	12	2894.2										
20	ЗХС	62355.6	61455.6	12	2	1250.0	5	4082.0	2	330.0	3	55813.6	60655.6	52070.1	9	1	200.0	4	3862.0	1	180.0	3	47828.1										
21	БШҮС	364041.5	189149.0	234	226	150561.0	3	19989.0	4	14680.0	1	3910.0	288823.8	116520.7	161	154	80838.8	2	17637.0	4	14680.0	1	3910.0										
22	ССАЖС	186008.8	82875.6	79	74	75547.6	2	1975.0	2	4670.0	1	683.0	114796.6	42721.3	47	42	35767.3	2	1975.0	2	4670.0	1	683.0										
23	ЗМС	214888.2	77891.0	165	49	39937.6	20	24964.1	91	12522.1	5	467.2	105505.0	40815.5	122	32	16356.7	15	15499.1	73	8819.1	2	140.8										
24	ХАНХС	24038.6	14885.0	22	15	1115.4	2	1500.0	3	1742.0	2	527.6	16547.6	9504.0	17	10	6134.4	2	1500.0	3	1342.0	2	527.6										
25	ХС	45615.7	24207.9	36	18	15424.2	5	7233.8	12	1470.4	1	79.5	21950.1	13446.7	26	11	8533.0	3	3613.8	11	1220.4	1	79.5										
26	ҮАААС	160489.0	77737.6	42	18	58253.0	4	2554.0	12	1520.6	8	15410.0	125469.0	54846.0	34	15	41816.6	3	1127.5	11	1382.1	5	10539.8										
27	БОНХС	29951.2	10185.2	39	28	6639.0	10	3033.0	1	513.2			10339.1	4469.3	27	18	2004.2	8	1951.9	1	513.2												
28	БХС	55169.2	21939.1	15	15	21939.1							53419.2	17739.1	14	14	17739.1																
29	ШЕЗ	22619.3	22619.3	7	5	18713.8	1	3409.8					7619.3	7619.3	5	3	3713.8	1	3409.8														
30	УДШ	10792.0	5792.0	6	1	5000.0	3	549.0	1	63.0	1	180.0	792.0	792.0	5	3	549.0	1	63.0	1	180.0												
31	АТТ	3001.4	3001.4	5	1	2000.0	3	821.4	1	180.0			3001.4	3001.4	5	1	2000.0	3	821.4	1	180.0												
32	УЕП	23341.6	20282.0	17	11	1812.2	3	719.8	3	1450.0			13180.8	10121.2	14	9	8112.2	2	569.0	3	1450.0												
33	ХЭҮС	20.0	20.0	1	1	20.0	1	20.0					20.0	20.0	1	1	20.0																
34	СЕХ	133.8	133.8	2	2	133.8	2	133.8					133.8	133.8	2	2	133.8																
НИЙТ ДҮН		3189107.4	1550249.3	1225	826	1273917.9	153	129004.9	189	51875.4	57	95451.1	2662133.8	1124305.3	972	625	894505.7	137	103629.8	164	46327.2	46	79842.6										



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2014 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 184

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23 дугаар зүйлийн 2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Улсын төсвөөс 2013 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав. Аудитын тайланг Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам болон холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлсүгэй.

Дөрөв. Аудитын тайланд дурьдагдсан зөрчлүүдийг арилган, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2014 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Сангийн сайд Ч.Улаан, холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт зөвлөсүгэй.

Тав. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор С.Төмөрхүүд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны... дугаар тушаалын хавсралт

Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалт

184
 2014.02.27
 10/10/14
 10/10/14

(сая төгрөгөөр)

№	Төлбөр, зөрчил хариуцагчийн		Төлбөр зөрчлийн товч утга	Аудитор, шинжээчийн нэр	Албан шаардлагын дугаар	Зөрчлийн дүн
	нэр	албан тушаал				
1	П.Гантулга	ХЯ-ны ТНБД	Зөрчил арилгуулах тухай	Д.Гандолгор Э.Уянга	02/47	574,2
2	Ш.Булга-Эрдэнэ	БШСЯ-ны ТНБД	Зөрчил арилгуулах тухай	Д.Гандолгор Э.Уянга	01/46	43,0
3	Б.Үнэнбат	УПЕГ-ын тамгын газрын дарга	Гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж ажиглах тухай	С.Сэрчорол С.Одонцэцэг	1/29	200,0
4	Н.Лүндэндорж	ШЕЗ-ийн дарга	Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах тухай	С.Сэрчорол С.Одонцэцэг	1/30	304,0
5	Х.Золжаргал	ҮХААЯ-ны ТНБД	Зөрчил арилгуулах тухай	Д.Гандолгор Э.Уянга	02/48	174,6
НИЙТ ДҮН						1295,8